

Эдмүнд Хүссэрл. Философи хэмээх чанд шинжлэх ухаан

Орчуулсан: О.Болор-Эрдэнэ, магистр

ШУА, Философийн хүрээлэн

Философи нь анхан цагаасаа чанд шинжлэх ухаан болохыг эрмэлзэж ирсэн, чингэхдээ онолын дээд шаардлагыг хангахаас гадна шашин суртахууны талаар дан оюун ухааны хэм хэмжээг мөрддөг амьдралын бололцоог хангах шинжлэх ухаан болох гэж хичээж байв. Үүнд их бага хүчин зүтгэл гаргав ч эл эрмэлзэл үгүй болсон удаагүй. Тэр бүү хэл, цэвэр онолын сонирхол, чадвар устах аюул нүүрлэсэн, эс бөгөөс эрдмийн эрх чөлөөг шашны хүчин хавчин хяхаж асан үест ч үгүй болоогүй юм.

Чанд шинжлэх ухаан болох эрмэлзлийг философи нь хөгжлийнхөө нэг ч эрин үед биелүүлж чадаагүй. Философийн эсрэг тэсрэг олон чиглэлүүдийг хөгжлийн голдиролд нэгтгэн Сэргэн мандалтаас эдүгээ хүртэл үргэлжилсээр сүүлийн эринд ч байдал өөрчлөгдсөнгүй. Чухамдаа философийн гэнэн тэмүүлэлд автагдахаас илүүтэй шүүмжлэлт тунгаан тусгахуйн ааг дөлийг туулан гараад аргын тухай судалгааг улам лавшруулсаар чанд шинжлэх ухаан болж төлөвших нь шинэ цагийн философийн зонхилох төрх болсон нь үнэн боловч энэ оролдлогын цорын ганц үр шим нь дан математикийн шинэхэн салбаруудын зэрэгцээ байгалийн болон хүмүүнлэгийн ухаанууд бие даасан байдлаа үндэслэн баталсан явдал байлаа. Тийн атал философи нь өдгөө ялган үзэх болсон онцгой утгаараа ч өмнөхтэйгөө адил чанд шинжлэх ухааны шинж чанар байхгүй. Энэ ялгарлын утга учир өөрөө хараахан шинжлэх ухааны баттай тодорхойлолт үгүй үлдсэн. Философи нь байгалийн болон хүмүүнлэгийн ухаануудтай* хэрхэн харьцах, тэдгээрийн ажилд утгаа бас л байгаль агаад оюун санаанд холбогдолтой философийн өвөрмөц зүйл шаардлагатай эсэх нь зарчмын шинэ хандлага бөгөөд түүн дээрээс өвөрмөц зорилт хийгээд арга өгөгдөж, тийнхүү философийн тал нь нэгэн зүйл шинэ хэмжээст хүргэх үү аль эсвэл байгалийн болон хүмүүнлэгийн ухаануудтай нэгэн ижил түшинд үлдэх эсэх нь одоо ч маргаантай хэвээрээ. Энэ нь, цаашилбал, философийн асуудлын утга учир өөрөө хараахан шинжлэх ухааны тодорхой чанартай болоогүйг илтгэж байна.

Тэгэхлээр түүхэн зорилтоороо бүх шинжлэх ухааныг даван гарсан хамгийн чанд шинжлэх ухаан - хүмүүний цэвэр үнэмлэхүй танин мэдэхүйд* (үүнтэй нягт уялдаатай цэвэр үнэмлэхүй үнэлэмж ба дур зоригт) эрмэлзэх чин санааг төлөөлөгч философи нь үнэхээр шинжлэх ухаан болон бүрэлдэх болоогүй. Хүн байх (Humanitat) мөнхийн үйл хэргийн хүлээн зөвшөөрөгдсөн сургагч ерөөс сургаж: объектив учир холбогдолтой сургаж чадахгүйд хүрчээ. Философидож болохоос философийг сурч болохгүй гэж Кант хэлэх дуртай байлаа. Энэ чинь тэгээд философийн шинжлэх ухаанч бус чанартайг хүлээн зөвшөөрсөн хэрэг биш гэж үү? Шинжлэх ухаан, үнэнхүү шинжлэх ухаан түгэхийн хэрээр сурч бас сургаж болдог, чингэхдээ хаа ч нэгэн адил утгаар баймуй. Хаана ч шинжлэх ухааны суралцахуй оюун санаанаас ангид хэрэглэгдэхүүнийг идэвхгүй хүртэхүй биш байдаг, ямар ч тохиолдолд тэр нь бүтээлч ухаанд төрсөн санааны үндэслэл ба үр дагаврын хамт нэгэн зүйл дотоод үйлдвэрлэл, өөрийн-идэвхт

* [Цаашид * -оор орчуулагчийн тайлбарыг, тоогоор эх бичвэрийн тайлбарыг тэмдэглэв] “Geisteswissenschaften” хэмээхийг ал ч хэлэнд буулгахад бэрх бололтой. Орос орчуулгад “наука о духе” гэж үгчилсэн маягтай бичжээ. Харин англи орчуулгад “humanistic sciences” гэжээ. Эдгээр шинжлэх ухаанууд нь хүмүүний билиг ухааны бүтээгдэхүүн, ялангуяа хүний нийгэмлэгийн оюун санааны тусгал бүтээгдэхүүнийг судалдаг гэж ерөнхийлөн ойлгож болно. Арга зүйн үндэс нэгтэй хүмүүнлэгийн ухаануудын ерөнхий нэр болох үүднээс энд дурдагдаж байна (Орч.).

* Хүссэрлийн хувьд “үнэмлэхүй мэдлэг” гэгч нь мэдлэгийн үнэн гэхээс илүүтэй үнэмлэхүй байдлаар өгөгдсөн (юмсын) мэдлэгийг заадаг.

ажиллагаанд тулгуурладаг. Философид объектив байдлаар ойлгогдох, үндэслэгдэх санаа байхгүй учраас түүнд суралцаж болохгүй байгаа юм. Өөрөөр хэлбэл, логикийн хувьд хөдөлшгүй тогтсон бөгөөд утга санааны хувьд тодорхой болсон асуудал, арга хийгээд онол бүрэлдэж амжаагүй учраас тэр.

Философи бол төгс бус шинжлэх ухаан гэж би хэлэх гээгүй, тэр нь ердөө ч шинжлэх ухаан биш, объектив үндэстэй шинжлэх ухааны агуулгын хамгийн бага хувиар аваад үзсэн ч шинжлэх ухааны хувьд эхэлж амжаагүй л хэлэх гэсэн юм. Бүх шинжлэх ухаан төгс биш, тэр бүү хэл бидний бахдалыг төрүүлдэг оновчтой шинжлэх ухаанууд ч төгс биш. Нэг талаас, тэдгээр нь дуусгавар болоогүй, тэдний өмнө байх нээлттэй асуудлуудын төгсөшгүй хаялбар танин мэдэхүйн эрмэлзлийг хэзээ ч тайван орхихгүй; нөгөө талаас, тэдгээрийн нэгэнт боловсорсон агуулгад учир дутагдал бий, тэдгээрийн онол ба нотолгоог эмхэлсэн тогтолцоо дотроос тодорхойгүй, боловсронгуй бус үлдэц хаа сайгүй илэрдэг. Гэтэл тэдгээрт байгаа номлолын агуулга үржин олширсоор ёс мэт өсөн нэмэгдэх боллоо. Байгаль шинжлэлийн болон математикийн гайхалтай онолуудын объектив зохистой байдалд, өөрөөр хэлбэл объектив үнэн байдалд ухаант хүний нэгэн ч эргэлзэхгүй. Ерөнхийдөө энд “хувийн санал”, “үзэл бодол” гэж байхгүй. Тийм зүйлс байсхийгээд тохиолдохын хэрээр шинжлэх ухаан төлөвшин тогтож амжаагүй, дөнгөж бүрэлдэн эхэлж байдаг бөгөөд тэр тусмаа шүүмжлэлд өртдөг¹⁶⁴.

Аливаа шинжлэх ухааны сая өгүүлсэн төгс бус байдалтай харьцуулахад философийн төгс бус байдал маш өөр юм. Тэр нь төгс гүйцээгүй тархай сургаалуудын тогтолцоог эрхшээдэг төдий биш, түүнд зүгээр л систем гэж байдаггүй. Энд бүхэн хамтдаа ба тусдаа маргаантай, тухайн асуудлын талаарх байр суурь бүхэн хувийн үнэмшлийн хэрэг, дэг сургуулийн ойлгоц, “үзэл бодол” байдаг.

Дэлхийн философийн утга зохиолоос оюун санааны нүсэр, тэр байтугай нухацтай ажилд үндэстэй санаа оноог эртний болон шинэ үеэс санал болгосон байлаа ч; цаашлаад энэ бүхэн ирээдүйн чанд шинжлэх ухаанч системийн байгууллыг дээд зэрэгт бэлдсэн байвч үүнээс философийн шинжлэх ухааны үндсийн хувьд эдүгээ юуг ч зөвшөөрөн хүлээх аргагүй, шүүмжлэлийн тусламжтайгаар жинхэнэ философийн сургаалыг эндээс тэндээс гарган авах найдвар байж болохгүй*.

Энэ үнэмшлийг дахин нэг удаа шулуун шударгаар илэрхийлэх учиртай, тэгэхдээ энд, чухамдаа философид онцгой эргэлт гарахыг гэрчлэхийн хамт философийн ирээдүйн "системүүд"-эд суурийг бэлдэхийг хүсэх «Логос»*-ын эхний хэдэн хуудаснаа хэлэх хэрэгтэй.

Хэрэг дээрээ, өмнөх үеийн философийн шинжлэх ухаанч бус чанарыг цохон тэмдэглэмэгц, философи нь чанд шинжлэх ухаан болох зорилгоо мөрдөхийг хүсэж байгаа эсэх, хүсэх ёстой эсэх, чадах эсэх асуултууд үүсэж байна. Шинэ эргэлтийг юу гэж ойлговол зохих вэ? Тухайлбал, чанд шинжлэх ухааны санаанаас хэлбийх үү, үгүй юү? Бидний туйлын зорилго

¹⁶⁴ Мэдээж хэрэг, маргаан дагуулсан философи-математикийн болон натур философийн асуудлыг энд өгүүлээгүй. Хэрэв тэдгээрт няхуур хандвал сургаалынхан зарим хэсэг агуулгаар тогтохгүй тухайн салбар ухаануудын шинжлэх ухааны ажлынхан утга учир («Sinn») бүхэлдээ хөндөгдөхөд хүрнэ. Тэдгээрийг тухайн салбар ухаанаас ялган үзэх ёстой нь учир гэвэл эдгээр салбаруудын ихэнх төлөөлөгчдөд тэдгээр нь хэрэг дээрээ хамааралгүй үлддэг. «Философи» хэмээх үг бүх шинжлэх ухааны нэришл дотор эрх биш эдгээр шинжлэх ухаануудад зарим талаар шинэ хэмжээс олгодог төдийгүй эцсийн явцыг тодорхойлдог судалгааны төрлийг тэмдэглэдэг байж болох юм. Гэвч хэмжээс гэдэг үг мөн дараах зүйлийг заана: эл шинэ хэмжээс хүрэх нь ирээдүйн үйл хэрэг болон үлдэвч чанд шинжлэх ухаан нь шинжлэх ухаан хэвээрээ, сургаалын агуулга нь сургаалын агуулга хэвээрээ байна.

* Эндээс цааших хэсэг газарт, Хүссэрл, философийн шинэ залгамж халаа болж оршин байгаа философи сэтгэлгүүдийг төдийлөн дэлгэрүүлэн авч үзээгүй нь, түүний хувьд феноменологи аргын хүрээнд “шинжлэх ухаанч” гэж тооцогдох сэтгэлгээ л гагцхүү философи сэтгэлгээ байж чадна.

* Уг өгүүлэл «Логос» (1911) сэтгүүлд анх хэвлэгдэж байжээ.

болохын хувьд манай шинжлэх ухааны ажлыг дээрээс гэрэлтүүлэх учиртай, бидний мөрөөсөл болсон "систем" бидэнд ямар утга учиртай байх вэ? Уламжлалт утгаараа философийн систем, өөрөөр хэлбэл бүтээлч суу ухаантнуудын толгойноос өвч тоногтой гарах Минерва* лугаа, тэр нь бусад тийм Минервас лугаа хожмын нэгэн цагт түүхийн аниргүй музейд хадгалагдан үлдэхийн тулд байх уу? Аль эсвэл үе үеийнхэн нүсэр бэлтгэл ажил хийсний дараагаар эргэлзэх аргагүй сууринаас эхэлж, аливаа сайн байгууламжийн адил чиг зорилгынхоо дагуу бие биедээ давхарлан сүндэрлэх үү? Эдгээр асуултаас сэтгэгчдийн зам салан одох учиртай.

Философийг урагш дэвшихэд хүргэсэн “эргэлтүүд” гол төлөв өмнөх үеийнхээ философийн хуурмаг шинжлэх ухаанч аргыг шүүмжлэн, шинжлэх ухаан байх эрмэлзлийг нь бут зохиж, оронд нь философийг чанд шинжлэх ухаанд хувиргах бүрэн ухамсарт эрмэлзлийг ажлын чиглүүлэгч журам болгосноор явагдсан болой. Сэтгэлгээний эрч хүч, юун түүрүүнд өмнөх үеийн философийн хэрэгсэлгүй өнгөрөөсөн эсвэл дутуу дулимаг ойлгосон чанд шинжлэх ухааны нөхцөлийг нь маш тодорхой болгоход төвлөрсний дараагаар л ямар нэгэн философийн онолын байгууламжийг бүтээн босгохоор оролдож эхэлдэг байнам. Чанд шинжлэх ухаанд тэмүүлсэн тийм бүрэн ухамсарт эрмэлзэл философид өрнөсөн сократ-платоны эргэлтийг, мөн шинэ үе эхлэхүйд схоластикуудын эсрэг шинжлэх ухааны тэмцэл, ялангуяа Декартын эргэлтийг тодорхойлдог. Тэдгээрээс эхтэй түлхэц XVII, XVIII зууны аугаа философиудаар дамжин, Кантын цэвэр оюун ухааны шүүмжээр хүчээ сэлбэж, цаашаагаа Фихтегийн философидолтод нөлөөлжээ. Судалгаа улам бүр үнэн эхлэл, асуудлыг шийдвэрлэгч томьёолол, зөв аргад чиглэгдэх болов.

Гагцхүү Романтик философид байдал өөрчлөгдөж эхэлсэн. Хэдийгээр Хегель өөрийн арга хийгээд сургаалын үнэмлэхүй учир холбогдолтойг хамгаалан мэтгэвч философийг шинжлэх ухаанч чанартай болгодог ганц зүйл - оюун ухааны шүүмжлэл түүний системд байдаггүй. Тиймээс, аливаа романтик философийн адил, энэ философи нь философийн чанд шинжлэх ухаан байгуулах түүхэн эрмэлзэл *сулрах юмуу гуйвахад* сүүлийн үест муу нөлөө үзүүлжээ.

Сүүлийн зүйл дээр буюу, уг эрмэлзэл гуйвах тухайд гэвэл, хэгелчүүд оновчтой шинжлэх ухаанууд хүчирхэгжихийн хэрээр XVIII зууны *натурализм* бат бөх өмөг түшиг олж авах үр дүнг өдөөсөн нь тодорхой бөгөөд аливаа абсолют идеаль чанар, үнэлэмжийн объектив чанарыг (*der Geltung*) хүчгүйдүүлсэн скептицизмийнхээ хамт шинэ үеийн философи ба ертөнцийг үзэхүйг зонхилон тодорхойлох болсон.

Нөгөөтэйгүүр, аливаа философи өөрийн цаг үедээ харьцангуй чанартайн тухай сургаалаараа хэгелийн философи нь шинжлэх ухаанч чанарыг эрмэлзэх философийн эрмэлзэл сулрахад нөлөөлсөн, - мэдээж, тэр сургаал нь абсолют учир холбогдолд тэмүүлж байгаа системүүдийн хувьд тэс өөр, түүхэн бус утгатай байж, түүнийг нь хэгелийн философид найддаг бүхэл бүтэн үе хүлээж авуутаа ерөөс абсолют философид итгэх итгэл алдарсан. Хэгелийн түүхийн метафизик философи нь скептик түүхчлэх үзэл (историцизм-орч.) болж хувирснаар шинээр "ертөнцийг үзэхүй"-н (*Weltanschauung*) философи бий болох нь үндсэндээ тодорхой болсон байдаг. Тэр нь чухамдаа манай үед ихэд дэлгэрч байгаа ба харваас ихэнх хэсгээрээ байгальчлах үзлийн (натурализмын-орч.) эсрэг шинжтэй, заримдаа бүр түүхчлэх үзлийн эсрэг шинжтэй, ерөнхийдөө бол скептик байхыг хүсэж байгаа бололтой. Гэтэл тэр нь Кант хүртэлх шинэ цагийн философийн дэвшилтэд шинж болсон шинжлэх ухааны сургаал руу цөхрөлтгүй эрмэлзэхүйгээс ангид байхын хэрээр философийн шинжлэх ухаанч эрмэлзэл сулрах тухайд дээр өгүүлсэн бүхэн түүнд хамаатай үлдэнэ.

* Минерва нь Эртний Грек-Ромын домогт гардаг мэргэн ухааны эх дагина юм.

Цаашдын эргэцүүлүүд хүмүүний соёлын аугаа ашиг сонирхол чанд шинжлэх ухааны философи боловсруулахыг шаардаж байгаа тухай санаа нэвт шингэсэн болно. Үүний зэрэгцээ философийн эргэлт манай цаг үед хийгдэх учиртай аваас тэр нь ямар ч тохиолдолд чанд шинжлэх ухааны утгаар философийг шинээр хувирган боловсруулах эрмэлзлээр өдөөгдсөн байх учиртай. Эл эрмэлзэл нь орчин цагт зохицохгүй этгээд зүйл огт биш ээ. Натурализм ноёрхсон цаг үед ч амин чухал байж чадна. Натурализм бүр эхнээсээ, философид чанд шинжлэх ухаанч шинэтгэл хийх санааг чухам гол нуруу болгон мөрдөж ирсэн, тэр бүү хэл уг санааг өөрийн эртний болон орчин үеийн хэлбэрүүддээ нэгэнт хэрэгжүүлчихсэн гэдэгт ямагт итгэлтэй байдаг. Гэвч учрыг нягталбаас, энэ бүхэн онолын худал үндэслэлтэй явагдаж, практикийн хувьд манай соёлд аюул нүүрлэхийн цондонг илтгэнэ. Байгальчлах үзлийн философийг шийдвэртэй шүүмжлэх явдал манай цаг үеийн маш чухал үйл хэрэг юм. Ялангуяа түүнийг үр дүнг шүүмжлэн няцаахаас илүүтэй үндэслэл ба аргыг шүүмжлэх явдал онцгой чухал. Нэгэнтээ натурализмын чанд эмпирик шинжлэх ухааны уршигт танин мэдэхүйн улмаас шинжлэх ухааны философийн бололцоонд итгэх итгэл алдагдсаныг гагцхүү тийм шүүмжлэл бүрэн сэргээж чадна. Энэ судалгааны эхний хэсэг тийм эерэг шүүмжлэлд зориулагдсан болно.

Харин манай цаг үед явагдаж байгаа эргэлтийн тухайд гэвэл, тэр нь гол төлөв байгальчлах үзлийн эсрэг чиглэгдсэн байх (үүнд түүний зөвтгөл буй) боловч түүхчлэх үзлийн нөлөөгөөр шинжлэх ухааны философийн шугамаас хэлбийж, харваас ертөнцийг бясалгахуйн (Weltanschauung) философитой нийлэхийг хүсэж буй бололтой. Хоёрдугаар хэсэгт энэ хоёр философийн зарчмын ялгааг тайлбарлаж, тэдгээрийн зохист байдлыг хэлэлцэнэ.

БАЙГАЛЬЧЛАХ ҮЗЛИЙН ФИЛОСОФИ

Натурализм ёс бол байгалийн нээлтийн үр дүнд үүссэн үзэгдэл, тэрхүү байгаль гэгч нь байгалийн хөдөлшгүй хуулиар орон-цагт ахуйн нэгдэл юм. Ийм үзэл санаа чанд танин мэдэхүйн олон зүйлийг үндэслэн шинэ тутам хөгжсөн байгаль шинжлэлүүдэд алгуур хэрэгжихийн зэрэгцээ натурализм дэлгэрчээ. Тун төстэй байдлаар, “түүхийн нээлт”-ийн үр дагавраас шинэхэн хүмүүнлэгийн ухаан бүрийн үндэслэл болж, хожим бас, түүхчлэх ёс гарч ирсэн. Заншсан ёсоороо юм бүхнийг: байгаль шинжлэлтэн байгаль гэж, хүмүүнлэгийн ухаантан түүхнээ тогтсон санаа гэж үздэг бөгөөд ийн үзэж болохгүй бүхнийг үл ойшоодог. Тэгэхлээр, бид жичдээ авч хэлэлцэх гэж байгаа байгальчлах үзэлтэн аваас эн тэргүүнээ физик байгалиас өөр юуг ч тоодоггүй. Оршин буй бүхэн: нэг бол физик юм (нэг ёсондоо физик байгалийн холбоост нэгдэл нэвт шингэсэн зүйл байж болно), эсхүл психик юм буюу, физик хувьсагчаас хамааралтай, сайндаа л “зэрэгцээ дагалдах баримт” байж болно. Оршин буй юм бүхэн психофизик уг чанартай - хөдөлшгүй хуулиар тодорхойлогдсон байна. Биднийхээр, эл ойлгоц гойд өөрчлөлтийг авчраагүй, позитивизмийн (Кантыг натуралист байдлаар тайлбарлагч эсвэл Хюмыг тууштай шинэчлэн хөгжүүлэгч аль ч) утгаараа гэвэл: физик байгаль нь сэрлийн цогцос, өнгө, гэрэл, даралт гэх мэтэд, харин психик юм нь энэ мэт болон бусад "сэрлүүд" -ийн нэмэлт цогцод сенсуалист байдлаар шийдвэрлэгддэг.

Өргөн тархсан материализмаас сэрлийн шинэхэн монизм ба энергетизмийг шувтаргал натурализмын туйлширсан болон тууштай ямар ч хэлбэрийн онцлог шинж нь нэгэнтэй *бүхий л интенциональ имманент өгөгдөхүүний хамт ухамсрыг байгальчлахуй*, нөгөөтэй *аливаа абсолют идеаль хийгээд хэм хэмжээний хамт санааг байгальчлахуй* мөн.

Сүүлийн зүйл дээр натурализм өөрийгөө няцааж орхидгоо анзаардаггүй. Аливаа идеаль зүйлийн жишээ болгон формаль логикийг авбал сэтгэлгийн хууль хэмээгч формаль-логик зарчмуудыг натурализм нь сэтгэхүйн уг (байгаллаг-орч.) чанарын хууль болгон тайлбарладаг нь

илэрхий билээ. Энэ нь аливаа скептик онолд байх тэр утгагүй байдалд хүргэдгийг өөр газар бид зохих ёсоор нотлон харуулсан юм¹⁶⁵. Тийм эрс шүүмжлэлийг байгальчлах үзлийн: аксиологи, практик философи, этик дээр, түүнчлэн байгальчлах үзлийн практик дээр өрнүүлж болно. Учир нь онолын утгагүй байдлаас мөрдөгдөн практикийн, үнэлэмжийн, ёс зүйн утгагүй үйл байдал (илэрхий зохимжгүй байдал) зайшгүй урган гарна. Хураангуйлан хэлбэл, натуралист үзэлтэн нь үйл байдлаараа идеалист бас объективист байдаг. Тэрээр шинжлэх ухаанч эрмэлзлээр дүүрэн, өөрөөр хэлбэл оюун ухаант хүн бүхэнд зайлшгүй байдлаар чухам үнэн, чухам гоо сайхан ба ач буян гэж юу юм, тэдгээр нь ерөнхий төрхөөрөө хэрхэн тодорхойлогдож байх ёстой юм, тусгай тохиолдолд бүртээ ямар аргаар танин мэдэгдэж байх ёстой юм гэдгийг мэддэг. Байгаль шинжлэл болон байгаль шинжлэлийн философийн ачаар зорилго үндсэндээ биелсэн гэж боддог. Тэрээр энэхүү ухамсраар олгогдсон урам зоригоороо “байгаль шинжлэл”-ийн үнэн, ач буян, гоо сайхныг хамгаалахад сургагч, үйл хэргийг шинэчлэгч болж товойдог. Тэрээр мөн онол бүтээхийн хамт ямар нэгэн үнэлэмж юмуу практик хэм хэмжээг хамгийн сайхан, хамгийн сайн нь хэмээн зөвтгөн санал болгохдоо өөрийн идеалист үйл байдлаараа дэвшүүлж байгаа тэр зүйлээ чухамдаа үгүйсгэдэг хуурмаг онолыг үндэслэн тогтоогч идеалист мөн. Түүнчлэн үнэлэмжийн ба практик журам зохицох ёстой, хүн бүр хүсэн үйлдэх учиртай тэрхүү үнэлэмжийг ер объектив байдлаар тогтоохын хэрээр, ер онолчлохын хэрээр санал болгодог. Байгальчлах үзэлтэн нь заана, номлоно, сургана, шинэчилнэ (Хёккел, Оствальд нар үүний тод жишээ мөн). Тийм атал тэрээр ямар ч номлол, ямар ч шаардлагад байх утга учрыг үгүйсгэдэг. Гагцхүү номлох нь эртний скептицизм лугаа - *expressis verbis*: “цорын ганц зүй зохистой нь оюун ухааныг (онолын, үнэлэмжийн, практик оюун ухааныг) үгүйсгэх явдал” лугаа адилгүй. Тэр бээр ийм зүйлийг өөртөө ойртуулах ч үгүй. Түүний утгагүй байдал ил биш, далд байдаг нь оюун ухааныг байгальчилдагт оршино.

Позитивизмийн болон прагматизмийн (релятивизмын талаар позитивизмыг даван гарсан) давлагаа улам бүр ихсэх болсон ч энэ талын маргаан үндсэндээ шийдэгдсэн билээ. Ийм нөхцөлд, мэдээж, үр дагавраас үндэслэгээ гаргахын хэрэгжих бодит хүчин сул болох нь илэрнэ. Ужиг үнэмшил сохор болгоно, гагцхүү туршлагын баримтыг олж хараад, гагцхүү туршлагын шинжлэх ухааны ач холбогдолтойг хүлээн зөвшөөрөгч нь байгалийн баримтуудтай зөрчилддөгийг туршлага дээр харуулахын аргагүй тийм утгагүй үр дагавар дотор мунгинаж орхисноо анзаардаггүй. Ийм үндэслэгээг «схоластик» хэмээн тэрээр таягдан хаях биз. Мөн үр дагавраас үндэслэгээ гаргах нь өөр талаараа урхагтай, чухамдаа түүний хүчинд соргог ханддаг хүмүүст муугаар нөлөөлөх нигууртай.

Философийг хатуу чанд шинжлэх ухаанд тулгуурлан, чанд шинжлэх ухаан болгох гэсэн натурализмын нэр хугарсан тул түүний арга зүйн зорилго ч гутагдсан мэт; энэ тал дээр, чанд шинжлэх ухаан гэгч нь позитив шинжлэх ухаан, шинжлэх ухааны философи төдий юм шиг, тийм шинжлэх ухаан дээр тогтож байгаа юм шиг сэтгэх хандлага дэлгэрсэн буй. Гэвч энэ нь ужиг үнэмшлээс хэтрэхгүй, чанд шинжлэх ухааны шугамаас хэлбийх нь буруу замд орохын шинж болохсон. Чухамдаа чанд шинжлэх ухаанч байдлыг бүх хүрээнд: байгалийн ба оюун санааны, онолын ба практикийн хүрээнд нэвтрүүлэхээр оролдох эрч хүчинд, ахуйн ба үнэлэмжийн философийн асуудлыг шинжлэх ухаанаар (“оновчтой гэх шинжлэх ухаанаар”) шийдэхийг эрмэлзэх хүчинд натурализмын ач гавьяа төдийгүй манай цаг үе дэх хүчин зүтгэлийнхэн гол хувь оршино. Орчин цагийн бүхий л амьдрал дотор шинжлэх ухаанаас хүчирхэг, тогтоон барьшгүй ялгуусан санаа байхгүй байж мэднэ. Түүний ялгуусан дэвшлийг юу ч зогсоож үл дийлнэ. Тэр нь, хэрэг дээрээ, ёсчлон тогтсон зорилгоороо бүгдийг хамарна. Түүнийг төгөлдөр байдалтай сэтгэвээс өөртэй нь тэнцэх эсхүл өөрийг нь давах нэг ч нэр хүнд байж болохгүй

¹⁶⁵ Logische Untersuchungen. Bd. I. 1900. үз.

оюун ухаан өөрөө байх юм. Натурализм нь онолын, үнэлэмжийн, практикийн идеальд эмпирик утга олгосноор тэдгээрийг гуйвуулдаг. Угтаа тэдгээр нь чанд шинжлэх ухааны талбарт холбогдолтой нь мэдээжийн хэрэг.

Тэгэхдээ үндэслэл үгүй болбоос ерөнхий нотломжийн өгүүлэмж өчүүхэн; уг зорилгыг хэрэгжүүлэх замыг олохгүй болбоос шинжлэх ухаанд найдахын ач тус бага. Иймд философи хэмээх чанд шинжлэх ухааны тухай санаа дурдагдсан болон бусад асуудлуудын өмнө хүчин мөхсөдөх ёсгүй гэвэл бид уг санааг хэрэгжүүлэх боломжийг мэдэж байх учиртай. Бид асуудлыг сөхөж, түүний цэвэр утгад нэвтэрвээс уг асуудалд зохицонгуй аргыг олмуй. Учир нь асуудлын мөн чанараас арга урган гарна. Шинжлэх ухаанд бат орших үнэмшил хийгээд жинхэнэ эхлэлд хүрэхийн тулд түүгээр хичээллэх хэрэгтэй ажээ. Үүнээ натурализмын үр дагавартай тэмцээд нэмэргүй, харин бусдаараа чухал бас ашигтай байж болох.

Харин бид натурализмын арга хийгээд үр дүнгийн талаар зайшгүй эерэг учраас ямагт зарчмын шүүмжлэл өрнүүлбэл энэ ч өөр хэрэг. Шүүмжлэлт сэтгэлгээ нь асуудал болгон авахад ямагт тодорхойгүй олон утгатай философийн арга барилын жинхэнэ учрыг олох хийгээд ялган танихад өдөөж өгөхийн хэрээр бидэнд хамгийн сайн зоригдол, зам мөрийн тухай төсөөллийг урин дуудаж, бидний санаа зорилгод эергээр нөлөөлнө. Ийнхүү эрмэлзэхүйс бидний сөгөөн маргалдах, урьд онцлон дурдсан *ухамсрыг байгальчилахуйн* философийн шинж чанарыг улам тодруулан авч үзье. Цаашид, дурдагдсан скептик үг дагавруудын илүү гүнзгий холбогдол илрэхийн хэрээр санааг байгальчлахуйтай холбогдсон бидний хоёрдох зэмлэлийн явц болон үндэслэлгээ тодорно.

Бидний шүүн шинжихүй байгаль шинжээчдийн нийтлэг философи эргэцүүлүүдэд чиглэгдээгүй, юун түрүүнд үнэхээр шинжлэх ухааны зэвсэг болж байгаа номлогч философийг: ялангуяа оновчтой шинжлэх ухааны алдар хүртэхийг ямагт санаархагч түүний тэдгээр арга ба салбарыг хэлэлцэнэ. Тэдгээрийг бусад философидолтыг үйл ойшоох хүртлээ маш үнэмшилтэй баримтална. Тэдгээр нь түүний оновчтой шинжлэх ухааны философидолдтод холбогдолтойг зүйрлэвэл: Галилейн оновчтой механикийн идэр хүчинтэй нь Сэргэн мандалтын харанхуй натурфилософи, аль эсвэл Лавуазьегийн оновчтой химитэй нь алихими ямар холбогдолтой мэт ажээ. Хэрэв бид оновчтой механиктай адилтгахуйц, үгүй ядахад бага зэрэг оновчтой бүтээгдсэн философийн талаар асуувал психофизикийн буюу, ялангуяа *сорилтот туршлагын психологийн* нэр заана, мэдээж, түүний оновчтой шинжлэх ухааны алдар хүндэд хэн ч халдахгүй нь ойлгомжтой. Тэр нь аль эртнээс зорьж эцэстээ нэг юм хэрэгжсэн шинжлэх ухааны-оновчтой психологи мөн гэгцгээнэ. Эцсийн дүндээ түүний ачаар л логик, танин мэдэхүйн онол, гоо зүй, ёс зүй, сурган хүмүүжүүлэхүйн ухаан бүгд шинжлэх ухааны үндэстэй болсноор барахгүй сорилтот туршлагын салбарууд болж хувирах замдаа эргэлт буцалтгүй орсон ажээ*. Ерөөс чанд психологи нь хүмүүнлэгийн ухаан бүгдийн үндэс, түүгээр үл барам метафизикийн үндэс болох нь аяндаа илэрхий хэмээдэг. Дашрамд хэлэхэд, сүүлийн зүйл дээр бол тэр нь гойд онцгой суур байж чадахгүй, учир нь бодит байдлын тухай хамгийн ерөнхий сургаалыг үндэслэхэд физикийн байгаль шинжлэл ч мөн оролцдог.

Бид, үүний эсрэгээр, ингэж хариулна: юун түрүүнд, товчхон эргэцүүлэн үзэхэд л илрэх зүйл гэвэл, психологи нь баримтын шинжлэх ухаан тул хэм хэмжээг тогтоох цэвэр зарчимтай харьцдаг цэвэр логик, цэвэр аксиологи ба практик зэрэг философийн салбаруудын үндэслэхэд тохиромжгүй болохыг анхаарвал зохино. Үүнийг нарийвчлан авч үзэхээс энд бид өөрсдийгөө чөлөөлж байна: энэ нь биднийг өмнө дурдсан утгагүй скептик байдалд хүргэх нь гарцаагүй. Харин цэвэр *Mathesis universalis* (тиймээс танин мэдэхүйд огт оролцохгүй) хэмээн цэвэр

* XX зууны эхэнд Герман, Австрид бүрдсэн философийн дүр төрхийг хэлж байна.

логигоос бидний ялгаж үзсэн танин мэдэхүйн онолын тухайд гэвэл гносеологийн психологизм ба физицизмийн эсрэг ихийг өгүүлж болох ба тэдгээрээс зарим нэгийг энд дурдвал зохино.

Ерөөс байгаль шинжлэлийн эхлэл гэнэн шинжтэй*. Түүний судалдаг байгаль бэлэн оршдог. Юмс аваас тайван хөдөлгөөн өөрчлөлтийн төлөвтөө хязгааргүй орон зайд, цаг хугацааны төлөвтөө хязгааргүй цаг хугацаанд оршдог нь аяндаа ойлгомжтой. Бид тэдгээрийг хүртэхдээ туршлагын жирийн бодомжоор дүрсэлдэг. Энэхүү аяндаа илэрхий өгөгдөхүүн сэлтийг объектив учир холбогдолтой шинжлэх ухааны чанд хэлбэрт танин мэдэх явдал бол байгаль шинжлэлийн зорилго мөн. Психофизик утгаар өргөжүүлсэн байгаль, түүнийг судлагч шинжлэх ухаан болох психологи бас ийм юм. Психик юм бол өөрийн төлөөх ертөнц (Welt für sich) биш; тэр нь “би” мэт, эсвэл “би”-гийн амсах туршлага мэт өгөгдсөн байдаг ба ийм юмс бие хэмээх тодорхой физик юмстай нэгдчихсэн байдаг нь туршлагаар илэрнэ. Энэ ч аяндаа илэрхий өгөгдөхүүн мөн*. Психик юмыг психофизик байгалийн аяндаа илэрхий холбоост шинжлэх ухаанчаар судлах, түүний объектив учир холбогдлыг тодорхойлох, түүний өөрөө бүтэх хувирах ба илрэх орших зүй тогтлыг нээх нь психологийн зорилт болой. Психологийн тодорхойлолт бүхэн физик аясаар огт гуйваагүй (бидний цаашдаа баримтлах) тийм өргөн утгаараа ч ipso психофизикийн тодорхойлолт мөн. Тэр бүү хэл психологи нь – туршлагын шинжлэх ухаан нь – явцуу утгатай психофизикийн хамаарлыг биш, харин ухамсрын өөрийнхөн үйл явцыг тодорхойлохыг хичээсэн газарт ч тэдгээр үйл явц нь байгалийн үйл явц мэт, өөрөөр хүн ба адгуусны ухамсарт холбогдолтой сэтгэгдэнэ. Хүн ба адгуусны ухамсар бас л аяндаа илэрхий зүйл бөгөөд тэдгээрийн биед холбогдолтой нь үзтэл ойлгомжтой. Психик юмсаас байгальд хамаарах харилцааг суутгах нь түүний байгалийн шинж чанар - цагт объектив тодорхойлогдогч баримтыг үгүй хийнэ. Иймээс дараах үндэслэл хөдөлшгүй тогтоогдсон гэж үзэцгээе: илэрхийлэгдсэн үгүй эсэхээс үл хамааран, психологийн бодомж бүхэн физикчилсэн байгалийн экзистенциаль тусгалыг өөртөө агуулдаг.

Үүнээс дараах үндэслэл ч тодорно: үгийн онцгой утгаар физикийн байгаль шинжлэл нь философи байж болохгүй, хаана ч хэзээ ч философийн үндэс болж болохгүй бөгөөд, гагцхүү метафизик зорилгын төлөөнөө өөрөөс нь урьдчилах философид тулгуурлаж гэмээнэ философийн үнэлэмжийг олох үндэслэл байх тохиолдолд тэдгээр нь психологийн тухайд адил хэрэглэгдэх ёстой.

Юутай ч тэдгээр үндэслэгээ учир дутагдалгүй.

Байгаль шинжлэл нь байгалийг өгөгдөхүүн сэлт мэт хүлээн авдаг талаар дурдсан тэр “гэнэн урсгал шинж”-ийг санахад хангалттай, - түүний гэнэн шинж мөхөшгүй гэмээр, түүний хөгжлийн аль ч цэг дээр дайралдсаар тэр бүх тохиолдолд байгаль шинжлэл нь энгийн туршлагад тулж очдог бөгөөд эцсийн дүндээ шинжлэх ухаан - туршилтын арга цөм эргээд туршлагын өөрт нь хүргэдэг. Мэдээж, байгаль шинжлэл өөрийн хүрээндээ ихээхэн шүүмжлэлтэй. Хэдийгээр машид хуримтлагдсан боловч оорцог сондгой төдийгөөс үл хэтрэх туршлага түүний хувьд ач холбогдол багатай. Тусгаар туршлагуудыг эмхлэх журамлах аргазүй, туршлага сэтгэхүй хоёрын баттай логик дүрэмтэй харилцан үйлчлэлд хэрэгцээтэй хэрэгцээгүй туршлага ялгагддаг ба тус туршлага бүр тодорхой ач холбогдлыг олоод ерөөс объектив учир холбогдолтой танин мэдэхүй - байгалийг танин мэдэхүй боловсруулагддаг. Гэвч бид ийм төрлийн туршлагаар хэчнээн

* Энд хэрэглэсэн “гэнэн (naive)” хэмээх үг нь үл тоомсорлосон утгагүй. Хүссэрлийнхээр, байгаль шинжлэлийн гэнэн байдал түүний уг чанартай холбоотой. Үүнээс үл шалтгаалан байгаль шинжлэл чухал тодорхой үр дүнгүүдэд хүрч чаддаг байна. Шинжлэх ухааны чанд философигүйгээр шинжлэх ухааны уг үндэс оновчтой байж чадахгүйг шүүмжилжээ.

* Өдөр тутмын танин мэдэхүйд юмс аяндаа илэрхий өгөгдөхүүн (англ. - a self-evident pre-datum) хэлбэрээр оршдог бөгөөд ийм жам ёсны төсөөллүүдийг феноменологийн үүднээс авч үзэхүйд оньсого болж хувирдаг.

хангагдав ч байгаль шинжлэл дотор оршиж, түүний дагуу сэтгэсээр байхад ерөөс туршлагыг төдийгүй туршлага - шинжлэх ухааны сэтгэхүйд асуултын тэмдэг тавьдаг шүүмжлэл бололцоотой бөгөөд орлогдошгүй байсаар байдаг.

Туршлага нь ухамсар болохын хувьд хэрхэн юмсыг олгох аль эсвэл юмсыг ердөө шүргэх вэ? Хэрхэн туршлагууд харилцан зөвдөж эсвэл зөвтгөгдөөд зогсохгүй, хэрхэн харилан субъективээр орлогдож эсвэл бататгагдах бэ? Ухамсрын тоглоом хэрхэн өөртөө юмсын объектив учир холбогдлыг гарган өгч чадах вэ? Ухамсрын тоглоомын дүрэм яагаад юмсаас хамааралтай биш вэ? Ухамсрын субъектив урсгалтай харьцуулахад алхам тутамдаа өөртөө байгалийг тусган мэдэхээр оролддог байгалийн шинжлэл хэрхэн бүх талаараа ойлгомжтой байж чаддаг бэ? Эдгээр асуултыг нухацтай тунгаамагц оньсого болж хувирдаг. Эдгээр асуултад хариу өгөх салбар бол танин мэдэхүйн онол гэдэг нь илэрхий билээ; тийн атал аугаа сэтгэгчдийн эдгээр асуултад зарсан хүчин зүтгэлийг үл харгалзан, энэ салбар нь шинжлэх ухааны ёсоор тэдгээрт санал нэгтэй, шийдвэр тодорхой хариулаагүй л байна.

Байгаль шинжлэлд тулгуурласан танин мэдэхүйн онолын, тиймээс психологийн танин мэдэхүйн онолын утгагүйг олж харахын тулд шийдлээ олоогүй эл асуудлын түвшинг гагцхүү чанд дараалалтай нь хадгалах шаардлагатай байсан болой (өмнөх онолууд дэс дарааллыг алдагдуулсан нь ойлгомжтой). Хэрэв тэдгээрээс зарим оньсого нь байгаль шинжлэлд имманент тогтсон байдаг гэвэл тэдгээр оньсогоын шийдэл өөрийн нөхцөл болон үр дүнгээр байгаль шинжлэлд трансцендент үлдэх нь ойлгомжтой. Байгаль шинжлэлд төрлөх шинжтэй (өөрөөр хэлбэл, түүнээс хэзээд салшгүй) асуудлын шийдлийг түүнээс хүлээх, тэр тусмаа асуудлын шийдэлд тустай нөхцөлийг олгож мэднэ гэж найдвал утгагүй эргэлэгт орно.

Тэгэхлээр танин мэдэхүйн онол нь тууштай байя гэвэл түүнд байгалийн тухайд шинжлэх ухааны болон шинжлэх ухааны өмнөх аль ч тогтоц, бас юмсын орон, цаг, шалтгаант чанарын эерэг (thetische) экзистенциаль нотолгоо бүхий хэллэг оролцох ёсгүй гэдэг нь тодорхой юм. Үүнээ судлаачийн эмпирик оршихуй болон психик чадвар зэрэг бусад зүйлийн экзистенциаль бодомжийг нэмж тооцох хэрэгтэй*.

Цаашилбал: хэрэв танин мэдэхүйн онол нь ухамсар ахуй хоёр харилцах асуудлыг судласу гэвээс гагцхүү ухамсарт харьцангуй ахуйг, ухамсрын чанартай зохилдонгуй "ухагдахуун"-ыг: нэг ёсондоо хүртсэн, дурссан, хүлээсэн, дүрлэсэн, төсөөлсөн, таньсан, ялгасан, итгэсэн, санал болгосон, үнэлсэн юм мэтсийг анхааруу. Чингэхүйеэ, тухайн судалгаа ухамсрын мөн чанарын шинжлэх ухаанч танин мэдэхүйд*, ухамсар *өөрийн мөн чанараар* бүрэлдэл тус бүртээ *"байгаа"*-д чиглэгдэх учиртай. Ямар ч атугай, ухамсар нь эдгээр бүрэлдлийн мөн чанартай зохицонгуй арга зам бүрт (илт, илт бусаар, төлөөлөн үзүүлэх, үзүүлэхүйгээр, дүрс тэмдгээр, сэтгэн дамнахуйгаар, аль нэгэн аттенсиональ модусаар юмуу бусад хэлбэрүүдээр) юуг *"тийн ухаарах"*-даа, яаж *"юмсыг"* сэтгэж, түүний үнэнхүү *"учир холбогдолтой"*, *"бодитой"*

* Хүссэрл объектив учир холбогдол (objective validity)-ын шинэ ухагдахуун гаргах замаар эмпиризмийн бэрхшээлийг шийдвэрлэх гэж оролдсон байдаг. Тухайлбал, Хюмын хувьд туршлагын олон янз байдлын объектив чанарыг хангах баттай зүйл байдаггүй. Хүссэрлийн хувьд объектив учир холбогдол (эш үндэслэл) нь туршлагын агуулгыг тогтвортой адилсаг чанараар хангахтай холбоотой бөгөөд энэ нь гадаад нөхцөлүүдтэй холбоогүй юм.

* Философийн уламжлалд оюун ухаан, туршлага хоёрыг нэгтгэхийг зорьдог байв. Хүссэрл, уг синтезээр үл хязгаарлагдан, туршлага нь оюун ухаанд багтан орж түүгээр зөвтгөгдөх ёстой, иймээс оюун ухааны шинжлэл болсон логик нь бас "туршлагын логик" болох ёстой гэж үздэг. Гагцхүү ухамсар (Bewusstsein)-ын зүйл үнэмлэхүй ахуйтай (Sein), түүний дээд хэлбэр нь оюун ухаан ажээ.

* Ил дурдагдаагүй боловч Хүссэрлийн "эпохе", "редукци" зэрэг нэр томъёоны агуулга илэрч байна. Тэдгээр нь "Ideen I" зохиол гарснаас хойш хэрэглэгдэх болсон. Тэдгээрээс ангидаар юмсын феноменаль чанар хүрэх боломжгүй гэдэг.

* Энд мөн чанарын танин мэдэхүй нь эйдетик танин мэдэхүйтэй ижил утгатай.

байгааг “илрүүлдэг”-т судалгаа чиглэгдэнэ. Ухаан зохист ярианы өгүүлэгдэхүүнээс шинжлэх ухааны өмнөх ба шинжлэх ухааны танин мэдэхүйн оногдохуун хүртэл зүйл бүрийн юмс бүр ухамсарт өөрөө тодрон үзэгдэх учиртай бөгөөд тухайн танин мэдэхүйн утгад зохилдох өгөгдөхүүн болно. Зүйл бүрийн ухамсар нь танин мэдэхүй нэрэн доор хураагддаг нь телеологи байдалтай гэмээр, тодруулж хэлбэл, тэдгээр ухамсар нь юмсын (оногдохууны-орч.) категорийн (Gegestands-Kategorien) дагуух бүлэг (танин мэдэхүйн функцийн зохих бүлэг) үүсгэдгийг гол холбоост нь, тэдгээрт зохицонгуй өгөгдөхүүний ухамсрын хэлбэрт нь судлах ёстой. Танин мэдэхүйн ажил хэрэг бүхэнд яригдах эрхийн асуулт ойлгогдсон байх, ёсчлон дагадаг эрхт байдлын мөн чанар болон эцсийн үндэслэгдсэн байдал, үнэнхүү учир холбогдол илэрхий байх шаардлагатай.

Юмс танин мэдэгдэх тодорхой арга хэлбэрээр оршин байгааг үзүүлсэн тийм оногдохуунт хэллэгийн утга гагцхүү ухамсрын өөрөөс нь илт чанартай болох ёстой, тэр тохиолдолд гүйцэд ойлгогдоно. Тэгэхийн тулд ухамсрыг цогцоор нь судлах шаардлагатай байдаг. Учир гэвэл ухамсар бүрэлдэл тус бүртээ танин мэдэхүйн боломжтой функцэд шилждэг. Ямар ч ухамсар нь “тухай ухамсар” (“Bewusstseins von”) мөн тул ухамсрын мөн чанарыг судалгаанд утга-ухамсар ба юм-ухамсар агуулагддаг.

Оногдохууны зүйлийг ерөнхий мөн чанарт нь судална гэдэг нь түүний өгөгдөхүүн болох аргыг шинжилж, түүнийг “илтэд онох” явцад үндсэн агуулгыг шавхаж гаргана гэсэн үг. Хэрэв ухамсрын мөн чанар ба хэлбэрүүдэд чиглэгдээгүй судалгаа байвал илтэд онох арга нь эрх биш өгөгдөхүүн болох, ерөнхий чанарыг олох арга чадварт хандсан тунгаан тусахуйд гарцаагүй оруулна. Эсрэгээрээ, аливаа оногдохууны зүйлийг илт онох нь ухамсрын мөн чанарыг шинжилгээнд зайлшгүй хүргэх бөгөөд түүний үр дүн болдог; ялангуяа тэр нь хамаарлын судалгааг эрхэлдэг гнеосологийн шинжилгээнд зайлшгүй хэрэгтэй. Иймд, хэдийгээр өөр хоорондоо ялгаатай байх ёстой боловч бид тийм төрлийн судалгааг “феномэнологийн” гэх нэрэн дор нэгтгэе.

Чингэвээс орчин цагийн хүмүүс огтхон ч төсөөлөлгүй нүсэр багтаамж бүхий нэгэн шинжлэх ухаантай бид тулгарч байна. Тэр бол, мэдээж, ухамсрын шинжлэх ухаан мөн боловч психологи биш - *ухамсрын байгаль шинжлэлд эсрэг ухамсрын феномэнологитой* бид учирч байна. Тэгэхдээ нэршлийн санамсаргүй давхцал энд яригдахгүй байгаа учраас феномэнологи, психологи хоёр маш ойр харилцаатайг урьдаас тооцох хэрэгтэй. Учир нь тэд ухамсартай харьцаж байдаг боловч тэдний арга зам хийгээд удирдамж (Einstellung) хариан адилгүй; үүнийг дараах байдлаар илэрхийлж болох юм: психологи нь байгалийн зохицолд орших юм мэт “эмпирик ухамсар”-тай, туршлагын удирдамжийн дагуух ухамсартай ажилладаг; эсрэгээрээ феномэнологи нь “цэвэр” ухамсартай, феномэнологи удирдамжийн дагуух ухамсартай харьцдаг.

Хэрэв үүнийг зөв хэмээвээс эндээс (психологи нь физикийн байгаль шинжлэлээс илүү дутуу гарахгүй тул тэр нь философи байж болохгүй гэх үнэнийг үл харгалзан) психологи нь (феномэнологиор дамжин) философид нэн ойр байх учир шалтгаан бий, түүнтэй хамгийн дотно үлдэх хувь тавилантай гэдэг нь урган гарна. Эцэст нь, эндээс ямар ч психологийн танин мэдэхүйн онол болбоос эпистемологийн асуудлуудын жинхэнэ утга учрыг алдагдуулах зүйлийг сурвалж болгодгийг: цэвэр ба эмпирик ухамсрыг хольж хутган, ухамсрыг “байгальчилдаг”-ийг урьдаас мэдэж болно. Миний үзэл санаа ийм юм, цаашид дэлгэрэнгүй тайлбарыг олох буй.

Сая дурдагдсанаас, ялангуяа психологи ба философи хоёрын дотно хамаарлын тухай хэлсэн зүйлс аваас философитой хавьтах юмгүй орчин цагийн оновчтой психологид тохирохгүй. Энэхүү психологи сорилт туршилтын аргад дулдуйдан өөрийгөө цорын ганц шинжлэх ухааны психологи гэж үзлээ ч, “бичгийн ширээний психологи”-ийг үзэн ядлаа ч — эл психологийг жинхэнэ психологийн шинжлэх ухаан мөн гэдэг үзэл нь уршигт төөрөгдөл болохыг хүлээн

зөвшөөрөх хэрэгтэй. Эл психологийн салшгүй шинж чанар нь ухамсрын цэвэр шинжилгээг (тодруулбал имманент ажиглан бясалгахуйн бололцоотой олон чиглэлд нээгдэх имманент өгөгдөхүүнүүдийг цэгцтэй “шинжлэх” хийгээд “дүрслэх”-ийг шаардагч шинжилгээг) тийм шинжилгээнээс ангид байхдаа өнгөц ойлгоцоос хэтрэхгүй психологийн баримтуудын хуримтлалын төлөөнөө үл ойшооход оршино. Тэрээр психофизик зүй тогтлуудыг сорилтоор тогтоохдоо: хүртэхүй, уран сэтгэмжээр онохуй, хэлэхүй, тооцоолохуй, дэгс тооцоолохуй, танихуй, горьдохуй, тогтоохуй, мартахуй зэрэг бүдүүн төрөл ойлголтуудаас хэтэрдэггүй. Гэтэл тэдгээр ойлголтын сан нь эсрэгээрээ түүний дэвшүүлэх асуудал хийгээд боломжтой нотолгоог хязгаарлахдаг.

Сорилт туршилтын психологи нь жинхэнэ (originare) психологитой харьцах харилцааг нийгмийн статистик нь нийгмийн ухаантай харьцахтай зүйрлэж болох байна. Хэдийгээр статистик нь чухал баримт цуглуулан тэдгээрээс зүй тогтлуудыг олж илрүүлдэг ч ихээхэн дам шинж чанартай. Социаль феномэнийг шууд өгөгдөхүүн болгодог, тэдгээрийг мөн чанарын дагуу шинжилдэг жинхэнэ нийгмийн ухаан л баримт болон зүй тогтлыг гүйцэт ойлгох, үнэн тайлбарлал хийх боломж олгодог. Үүн лугаа сорилт туршилтын психологи чухал психофизик баримт, тогтмолыг илрүүлдэг ч тэдгээр нь психик юмсыг имманент шинжлэгч ухамсрын нэгэн тогтолцоот шинжлэх ухаангүйгээр гүнзгий ойлгоц, гүйцэт шинжлэх ухааны үнэлгээг олох боломжгүй.

Бид энд түүний аргын дутагдалтай тулгарч байгааг хэлбэл өөрийгөө-ажихуйн аргатай тэмцэхийн хэрээр, өөрийгөө-ажихуйн аргын дутагдлыг сорилт туршилтын аргаар даван туулахаар зүтгэхийн хэрээр оновчтой психологийн ухамсарт дутагдал байсаар байх болно. Тэгэхдээ аргын дутагдлыг даван туулж болох нь түүгээр хийх зүйлийг огтхон ч үгүйсгэхгүй. Юмс дундаа психик юмсын эрхшээл нь ухамсарт хүрч шинжлэх боломжгүй шахуу нэн хүчтэй илэрдэг. Тэдгээр нь тийм нөхцөлд эл психологийн оновчтой байдалд хүрэхийг эрмэлздэг (нүсэр биш зорилго мөрдөгдсөн үед зарим газраа оновчтой байж чаддаг) сүрхий байдалтай нь гайхаш барам эсрэг тэсрэг гэнэн феномэнологи шинжээрээ гагцхүү ялгагддаг. Ийм зүйл сорилт туршилтаар тогтоогдсон танин мэдэхүйд мэдрэхүйн субъектив үзэгдлүүд хөндөгдсөн газар тохиолддог (ийм зүйл мэдрэхүйн субъектив үзэгдлүүдийг дүрслэн тэмдэглэх нь “объектив” үзэгдлүүдийн үеийнх шиг, нэг үгээр хэлбэл, биднийг ухамсрын хүрээнд аваачих нэмэлт ойлголт ба тайлбар үгүй явагдсан ч тохиолддог); цаашилбал, сорилт туршилтаар тогтоогдсон танин мэдэхүй ухамсрын нарийн шинжилгээ хийгдээгүй ч элбэг тохиолддог психик юмсын бүдүүн тойм ангийг нь (энэ ажлын психологи утгыг баримтлахгүйгээр) олж тогтоосон газар тохиолддог.

Эрс психологийн зүйл дурын шинжилгээнд өртөх боломжгүй байдгийн шалтгаан нь тухайн ажлын арга, утга санаа хийгээд (арга зүйн талаар туршлага суугаагүй нэгэн ялгаж эс дийлэх) зүйл бүрийн ухамсрын баялаг агуулга зөвхөн нэгэн тогтолцоот цэвэр феномэнологид илэрдэгт оршино. Чингэхүйеэ орчин цагийн оновчтой психологи нь арга зүйн хувьд чанд шинжлэх ухаан болж боловсорсон гэж өөрийгөө үнэлдгийн улмаас психофизик зүй тогтолт психик юмсын утгыг байцаан шинжлэх буюу жинхэнэ психологийн ойлгоцод хүрэхийг хүсэх газраа *de facto* шинжлэх ухаанч бус болчихдог. Эсрэгээрээ илүү гүнзгий танин мэдэхүйд эрмэлзэх үест психик юмсын бүрхэг төсөөллийн дутагдалтайгаас асуудлын тавилт тодорхой бус болж, хуурмаг дүгнэлтэд хүргэдэг. Субъект дундын баримтыг тогтооход сорилт туршилтын арга ямагт үл хүрэлцэнэ. Энэ нь сорилтоор гүйцэтгэж дийлэхгүй ухамсрын шинжилгээг шаарддаг.

Штумпф, Липпе нарын шадар нөхдийн цөөхөн сэтгэлзүйчид сорилтийн психологийн уг дутагдлыг ухаарч, психологийн судалгаанд эрин цагийг эхлүүлсэн Брентаногийн хувь нэмрийг үнэлж чадсан учраас түүний интенциональ туршлагын аналитик тоочин дүрслэх судалгааг уламжлан явуулсаар байсан боловч сорилтын аргыг шүтэгчдийн зүгээс ердөө ч тоож үзээгүй, эсвэл тэдгээрийг сорилтын үүднээс үнэлэхээс хэтрээгүй. Тэдгээр хүмүүсийг “схоластикчид” гэж

шүүмжилсээр байв. Имманент зүйлийг нухацтай шинжлэх, тэгэхдээ имманент шинжилгээний ганц боломжтой арга: мөн чанарын шинжилгээний (Wesensanalyse) аргаар шинжлэн судлах шинэ цагийн оролдлогуудыг схоластик хэмээн нэр зүүж, таягдан хаясанд ирээдүй хойч үеийнхэн гайхширах шалтаг хаа мундах буй.

Үүний шалтгаан гэвэл ийм судалгаа гол төлөв хэлэн дэх психик юмсын нэршлээс эхэлж, тэдгээрийн утгад нэвтрэхдээ тухайн тэмдэглэгээгээр анхандаа бүрхэг, санамсаргүй үзэгдэлтэй харьцан ухаарах болсонд байгаа юм. Мэдээж, схоластик онтологизм хэлийг хөтөч болгох (мэдээж схоластик судалгаа бүгд онтологийн судалгаа байгаагүй) аргаар баримтын танин мэдэхүйд хүрэхийг санаархахдаа үгийн утгаас аналитик бодомжийг гарган авснаар өөрийгөө булшилдаг. Тиймээс ямар ч үгэн ойлголтоос бодомж гарган авдаггүй, гагцхүү ажиглан бясалгах замаар хэлний тэмдэглэдэг феномэнд нэвтэрдэг эсхүл туршлагын болон математикийн ойлголтын илт хэрэгжилтийн феномэнд гүнзгийрдэг феномэнологийн аналитикчидад мөнхүү схоластикчид нэр зүүх нь зохистой байж чадах уу?

Үүнд хэдэн зүйлийг бодолцвол тустай: (нэн тэргүүнээ психологчид болон феномэнологчидийн судлагдахуун байвал зохих) психик юм бол эрхбиш “тухай ухамсар”-ын шинж чанарыг агуулдаг; “тухай ухамсар” нь ээдрээтэй олон хэлбэртэй; эхлэн шинжилгээ хийхэд аливаа хэллэг өөртөө-ойлгоц, обьектив тоочилтод тустай байж болох ч ямар ч хэллэг хувирамтгай бөгөөд салаа утгатай; тэгэхлээр, мэдээж, нэн түрүүнд нүдэнд тусах бүдүүн алдаа мэдгийг залруулахаас өөр явдалгүй. Феномэнийг шинжлэх замаар л шинжлэх ухааны хэлийг эцэслэн тогтооно. Тийм шинжилгээ хийгдээгүй цагт хуурамчаар үйлдэгдсэн өмнөх ойлголтуудаас (гагцхүү одоо л мэдэгдэж байгаа) шинэ салаа утгат чанаруудыг гарган авсаар ахиц амжилттай яваа харагдана. Энэ нь тийм байхаас аргагүй, учир нь юмсын уг чанараас үндэстэй. Үүгээр шинжлэх ухаанч оновчтой психологийг сахин хамгаалагчид “үг төдий”, “хэл зүй төдий” “схоластик төдий” хэмээн үл тоомсролдог ойлгоцын учир тодорхой болно.

Схоластикчдын эсрэг бослого өрнүүлсэн эрин үед: “үгсийн хоосон цэцэрхэл сөнөтүгэй!” нь тэмцлийн уухай болж байв. Бид юмсын өөрөөс нь лавлах ёстой. Бидний үг хэлэнд утга учрыг, зохист эрхийг олгож чадах гагцхүү тэр ажиглан бясалгахуй руу, туршлага руу буцсугай. Түмэн зөв өө! Харин бид психологид харьцах ёстой тэр туршлага, тэдгээр юмс гээч юу сан билээ? Соригдогч хүнээс бидний олж мэддэг тэдгээр хэллэгүүд юмсыг илэрхийлэх үү? Психик юмыг гаргаж хэлсэн тэдний “туршлага”-ын хэллэгт тайлбар байж болох уу? Соригчид хэлэхдээ: энэ хоёрдогч туршлага; анхдагч туршлага нь тэдний урьдын өөрийн хүртэхүйд байдаг бөгөөд өөрийгөө ажигуй биш гэдгийг баттай хэлж болно гэдэг. Сорин туршигчдын өөрсдөд нь өөрийгөө ажигуйн болон (тэдний хэлэлцдэгээр, өөрийгөө ажигхаас үл хэтрэх) “бичгийн ширээний психологи”-ийг шүүмжлэх тавилан оногдсон гэж бахархах нь олонтоо. Ийнхүү тэд “тохиолдлын, санамсаргүй, зориуд бус туршлага”¹⁶⁶-ын хэлбэртэй шууд туршлагыг ашиглаж, гутаагдсан өөрийгөө ажигуйг халах сорилтын арга боловсруулсан аж. Нэг талаар, хэт дэвэргэлийг эс тооцвол, энд сайн тал байгаа нь эргэлзээгүй, нөгөөтэйгөөр, энэ психологийн гол дутагдлыг анхаарууштай: тэрээр бусдын туршлагыг догдлон мэдэхүйд* хэрэгжих шинжилгээ хийгээд тухайн нөхцөлд ажиглагдаагүй өөрийн сэтгэл хөдлөлд тулгуурласан шинжилгээ хоёрыг физикийн байгаль шинжлэлийн үүднээс хийгдсэн туршлагын (тэр бүү хэл дам туршлагын) шинжилгээтэй ижил түвшинд авч үздэг. Ингэснээр физик юмны туршлагын шинжлэх ухаан нь физикийн байгаль шинжлэл байдаг шиг психик юмсын туршлагын шинжлэх ухаан байх юм гэж боддог. Тэрээр гэнэн туршлагаас (тэдгээр туршлага нь ажиглалтын ба ажиглалтын биш үү,

¹⁶⁶ Wundt: Logik II.170. үз.

* Einfühlung /Empathy: Хүссэрл энэ нэр томъёог хүлээн авсан ч түүний хэт сэтгэл хөдлөлийн талыг хэрэгсэхгүй үлдээдэг. Нэг субъект нөгөөгийнхөө туршлага, сэтгэлийн төлөв руу ямар нэгэн байдлаар нэвтрэн орсон нууцлаг байдлыг заахад хэрэглэгддэг.

ухамсарт үйлчлэн байна уу эсвэл дуртгалд, догдлон мэдрэхүйд явагдаж байна уу гэдгээс үл хамааран) шинжлэх ухааны туршлага бүрэлдэхийн тулд урьдаар ухамсрын өвөрмөц шинжилгээ хийгдэх учиртайг анзаардаггүй.

Үүнийг ойлгомжтой болгох гэж оролдъё.

Сэтгэл судлаачид нь тэдний психологийн мэдлэг болбоос туршлагаар бий болдог, өөрөөр хэлбэл гэнэн дуртгал юм уу, дуртгалд догдлон мэдэхүйг туршлагын дүгнэлтийн үндэс болгохдоо сорилтын арга хэрэгсэл ашиглана гэдэг. Хэдий тийм боловч гэнэн туршлагын өгөгдөхүүнийг тоочин дүрслэхтэй зэрэгцэн явагдах түүний имманент шинжилгээ, логик ухагдахуун нь цөөн тооны нөөц ойлголтоор хийгддэг. Тэдгээр ойлголтын шинжлэх ухааны үнэт чанар нь цаашдын аргазүйн алхам бүрд шийдвэрлэх ач холбогдолтой. Эдгээр ойлголтууд нь сорин турших тавилттай асуулт ба аргын улмаас судалгааны явцад хөндөгдөлгүй үлдэж, эцсийн үр дүнд (өөрөөр хэлбэл, дараагийн ээлжид судалгааны зорилго болох шинжлэх ухааны туршлагын дүгнэлтэд) шилждэгийг товчхон эргэцүүлэхэд харагдаж байна. Нөгөөтэйгөөр, тэдгээр ойлголтын шинжлэх ухааны үнэт чанар анхнаасаа бэлэн байх аргагүй, бас соригдогч ба соригч хоёрын туршлагаас бий болох аргагүй, туршлагын үндэслэлүүдийн логикоос тогтоох аргагүй: чухам энд л мөн чанарын феномэнологи шинжилгээ (Wesensanalyse) байх ёстой. Натуралист сэтгэл судлагчид зохимжгүй сонсогдох боловч энэ нь эмпирик шинжилгээ биш.

Эмпирик ухамсрын хөгжлийн түүхээс улбаатай (иймд сэтгэлзүйд нэгэнт шингэн орсон) хоёр ондоо үнэмшил Локкын үеэс эдүгээ хүртэл хутгалдаж ирсний: нэг нь логик төсөөлөл урьдын туршлагуудаас “үүсдэг” гэх үнэмшил, нөгөөх нь аливаа ойлголт хэрэглэгдэх бололцоотой эсэх (тухайлбал, дескриптив бодомжид хэрэглэгдэх бололцоо) эрхийг туршлагаас олдог гэх үнэмшил юм.

Энэ нь ойлголтын үнэнхүү учир холбогдол хийгээд мөн чанарт тохирох эсэх (мөн тухайн тохиолдолд болон цаашдаа хэрэглэгдэх эсэх) эрхийн үндэслэл гагцхүү хүртэхүй эсвэл дуртгалаас олдоно гэсэн үг. Бид тоочин дүрслэхдээ: хүртэхүй, дуртгал, уран сэтгэмж, хэллэг гэх мэт үгсийг хэрэглэцгээдэг. Тийм ганц үгний бүрэлдэхүүнд хэдий хир имманент хэсэг - дүрслэгдсэн юмсыг “онож барих”-даа бидний нэвтрүүлсэн хэсэг агуулагдаж байдаг бол оо! Эдгээр үгсийг ухамсрын “түүх”-нээ тодорхой бусаар олдсон нийт дундын бүрхэг утгаар хэрэглэхэд л хангалттай юу? Бид энэ түүхийг мэдлээ ч ямар тусыг хүртэнэ гэж?, Харваас бүрхэг ойлголт шинжлэх ухаанч бус тэр нөхцөлд юуг өөрчилж чадна гэж? Гойд сайн ойлголт байхгүй тохиолдолд, тэдгээрт агуулагдсан бүдүүн бараг ялгаа нь амьдралын практикт хангалттайг бодолцон хэрэглэсээр байж болно. Тэгтэл өөрийнхөө объектыг тодорхойлогч ойлголтыг шинжлэх ухааны тодруулга хийгээд арга зүйн боловсруулалтгүй үлдээдэг тэр психологийг “оновчтой байдал” –д хүрэхийг эрмэлздэг гэж болох уу? даа. Мэдээж, жин, дулаан, цул гэх мэт тийм ердийн ойлголтоор дүүрэн физикээс илүү гарахгүй. Орчин цагийн психологи нь “сэтгэл”-ийн тухай шинжлэх ухаан байхыг хүсэхгүй, харин “психик феномэн”-ий тухай шинжлэх ухаан болохыг эрмэлзэж байна. Хэрэв зээ тийнхүү хүсэх аваас эдгээр феномэнийг бүхий л логик чанд байдалтай тодорхойлж, тоочин дүрслэх учиртай. Тэрээр арга зүйн ажлын явцад зайлшгүй чанд ойлголтуудыг эзэмших ёстой. Энэхүү арга зүйн ажлыг “оновчтой” психологийн хаана нь гүйцэтгэсэн байгаа вэ? Үүнийг бид, түүний нүсэр зохиол туурвил дотроос эрээд нэмэргүй.

Хэрхэн жирийн, “будилаантай” туршлага шинжлэх ухааны туршлага болж чадах тухай, хэрхэн объектив учир холбогдолт туршлагын бодомжуудыг тогтооход хүрэх тухай асуулт бол аливаа туршлагын шинжлэх ухааны арга зүйн гол асуудал мөн. Түүнийг in abstracto байдлаар, ялангуяа цэвэр философийн байдлаар шийдвэрлэх гэх хэрэггүй: түүний хариулт түүхнээ бэлхэн буй. Тэр нь чухам ийм юм: туршлагын шинжлэх ухаанд мөр гарсан суутнууд зохих туршлагын

аргын утга санааг in concrete, интуитив байдлаар* онон барьж, туршлагын хүрэлцээтэй талбарт түүний цэвэр хэрэглээг дэлгэрүүлснээр туршлагын объектив учир холбогдолтой тодорхойлолтын зүйлийг боловсруулсан ба ингэснээр шинжлэх ухааны эхлэлийг бүтээж чадсан. Тэдний үйл ажиллагааны гол сэдэлд ямар ч нээлт бус, харин туршлагын өөрийнхөн утга санаанд гүнзгийрэн орохуй, өөрөөр хэлбэл тэдгээрт өгөгдсөн “ахуйн” утгад нэвтрэхүй тус хүргэсэн хэрэг. Учир юу хэмээвээс, тэр нь “өгөгдөхүүн” мөн эсэхээс үл хамааран, “тодорхой бус” туршлага дахь “будлиантай” өгөгдөхүүн мөн. Иймээс: үнэндээ юмс хэрхэн оршдог вэ?; тэдгээрийг хэрхэн объектив учир холбогдолтой тодорхойлох вэ?, өөрөөр хэлбэл ямар зэгсэн сайн “туршлагаар”, ямар аргаар тодорхойлох вэ? гэсэн асуулт аяндаа гарна. Гадаад байгалийг танин мэдэх явцад гэнэн туршлагаас шинжлэх ухааны туршлагад, ердийн бүрхэг ойлголтоос шинжлэх ухааны ойлголтод хүрэх эхний чухал алхмыг зөвхөн Галилей* маш тодорхой хэрэгжүүлсэн. Харин психик юмсыг танин мэдэхүй ба ухамсрын талбарын тухайд гэвэл оновчтой байгаль шинжлэлтэй эн тэнцэхүйц бүрэн эрхтэй гэж саймширдаг “сорилт”-ын психологи бидэнд байгаа хэдий ч, тэр нь үндсэндээ – үүнийг өчүүхэн ухаарсан атугай ч - галилейн өмнөх эрин үед амьдарсаар байна.

Тэрээр үүнийг ухаарахгүй байгаа нь хачирхалтай санагдаж магадгүй. Шинжлэх ухаан үүсэхээс өмнийн байгалийн тухай гэнэн мэдлэгт, байгаль ёсны-гэнэн туршлагын ойлголтуудаар байгаль ёсны туршлагын өөрт нь холбогдуулан тавьж болохооргүй тийм зүйл байгаль ёсны туршлагад тулгарч байгаагүйг бид ойлгож байна. Гэнэн байдлаасаа болоод, юмс үзэгдэл уг чанартай байх бөгөөд эл уг чанар болбоос туршлагат-логик үйл явц* дахь оновчтой тогтсон ойлголтуудаар тодорхойлогдож болохыг анзаарсангүй. Харин психологи нь институт, оновчтой багаж хэрэгсэл, нарийн бодож хийсэн арга зүйгээрээ өмнөх үеийнхээ сэтгэлийн тухай гэнэн мэдлэгээс хавьгүй хол ахисан гэж бахархах нь зөв өө. Тэр бүү хэл, цаг үе бүрд ахин шинэчлэгдсээр ирсэн аргын тухайн нямбай эргэцүүлэлд нь хүртэл дутагдал илэрч байсангүй. Тэрээр зарчмын нэн чухал зүйлийг хэрхэн анзаарахгүй өнгөрөөж болох вэ? Тэрээр ангид байх боломжгүй цэвэр психологи ойлголтууддаа: туршлагад бодитой өгөгдсөн зүйлээс гарган аваагүй, харин түүнд хэрэглэсэн зайлшгүй агуулгыг олгодгийг хэрхэн анзаарахгүй байж болох вэ? Психик юмсын утгад хандахын тулд ойлголтын эл агуулгыг шинжлэн, туршлагад хэрэглэсэн бөгөөд туршлагатай харьцуулахад априор байдаг зохих феномэнологи холбоосны ач холбогдлыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй бус уу? Тэрээр үнэхээр психологийн мэдлэг бүтээхийг хүсэж байвал сорилтын аргын урьдчилсан нөхцөлүүд түүний өөрөөс нь үндэслэгдээгүй байж болохгүйг, бас түүний ажил физикийн ажлаас эрс ялгаатайг (учир физик нь төсөөлөн бодсон байгалиа хайж олохын тулд аливаа феномэналь зүйлийг оргүй суутгадаг байхад психологи нь феномэний өөрийнхөн тухай шинжлэх ухаан байхыг хүсмүү) хэрхэн анзаарахгүй байж болох вэ?

Түүний байгалийн шинжлэлээр хөөцөлдсөн натуралист гажуудал нь сорилтыг гол ажилд тооцох болсны улмаас энэ бүхэн анхааралд өртөлгүй үлдсэн ба үлдэх ёстой байсан ажгуу.

* Интуитив байдлаар: юмсын мөн чанарт нэвтэрсэн суутнуудын интуици нь жам ёсны зүйл бөгөөд үүнийг феномэнологи шинжилгээний эцэст юмс үзэгдлийн ахуйн утгад нэвтрэхүйтэй шууд адилтгаж болохгүй (магадгүй “оргиналь” сэтгэгч бүхний сэтгэлгээнээс феномэнологийн зүйл олдож болохыг үгүйсгэхгүй).

* Шинжлэх ухааны эрдэмтдийн үзэл хандлагын өөрчлөлт хувиралд Галиллейн оруулсан хувь нэмэр болон тэднийг дан “объективжсон” хандлагад түлхэн оруулах болсон төөрөгдөл зэргийг “Krisis” зохиолоос үзнэ үү.

* Өмнөх үеийн философичдын эргэцүүлэл туршлагын өгөгдөхүүнд тулгуурлаж байсан бол, Хүссэрл туршлагын өөрийнхөн “логос”-ыг (суурь рациональ чанарыг) олохыг эрмэлзэж байв. Туршлага өөрийнхөө оногдохууныг тохинуулан бүтээж чадах тохиолдолд л түүнийг зөвтгөн тайлбарлахуйц байх нь феномэнологийн нэгэн чухал сэдэв болдог. Энэ бүхэн нь гагцхүү Кантын формаль априори байх нь хангалтгүй, үүнээс гадна материал априори байх хэрэгцээнээс үүдэлтэй.

Тэрээр ямар аргын тусламжтайгаар “будлиантай” байдлаас (ерөөс психологийн бодомжид оногдохгүй тэдгээр) ойлголтын объектив учир холбогдол хийгээд тодорхой байдалд хүрч болох илүү гүнзгий судалгааг өөрийнхөө психофизик сорилтын бололцооны тухай хичээнгүй гярхай эргэцүүлэл, туршлагыг зохион байгуулах төлөвлөл (Versuchsanordnungen), багаж хэрэгслийн боловсруулалт, болзошгүй алдааны эх сурвалжийн мөрдлөг гэх мэтэд ухвар мөчид орхигдуулсан. Психик юмсыг байгалийн дүрслэл болгохдоо “мөн чанар”-ын психофизикээс өмнийн гагцхүү түүнд шинж төгс байх ёстой зүйлийг үл эрхлэн орхигдуулсан болой. Тэрээр психологийн туршлагын “утга”-д юу байгааг, психик юм яг өөрөө (von sich aus) утгад ахуйн аргад ямар “шаардлага” тавигдах талаар дэнслэн үзээгүй болой.

Эмпирик психологи бий болсон XVIII зуунаас эхлэн түүнийг ямагт төөрөгдүүлж ирсэн зүйл гэвэл физик-химийн дүр бүхий байгаль шинжлэлийн аргын тухай худал төсөөлөл мөн. Зарчмын түгээмэл байдалд нь үзвэл ямар ч туршлагын шинжлэх ухааны арга нэгэн ижил болой, иймд психологи ч физикийн байгалийн шинжлэх ухаантай адилхан байна гэсэн үнэмшил давамгайлдаг. Метафизик нь нэгэнтээ геометрийн, нэгэнтээ физикийн аргыг өнгөц дуурайсаар он удаа жил зовлоо. Харин одоо тэр нь психологи дээр давтагдаж байна. Сорилтот-оновчтой психологийг үндэслэгчид нь физиологичид, физикчид байсан нь санамсаргүй хэрэг биш. Гэтэл үнэн арга болбоос урьдаар бидний тулгасан бодомж, төсөөллөөс бус, харин судлагдахууны уг чанараас урган гарна*. Байгаль шинжлэл нь юмсын гэнэн мэдрэгдэх байдалд илрэн гарах тодорхойгүй субъектив чанараас оновчтой объектив шинж чанар бүхий объектив юмсыг боловсруулдаг. Иймээс психологи нь гэнэн танин мэдэхүйн психологи тодорхойгүй байдлыг объектив-учир холбогдолт тодорхойлолтод хүргэх ёстой, ингэснээр объектив арга бий болно гэгцгээдэг. Мэдээж тэр нь байгалийн ухаанд байлдан дагуулалтаар өөрийгөө гайхалтайгаар нотлон харуулсан сорилтын аргаас өөр юм биш.

Тийн атал туршлагын өгөгдөхүүнийг объектив тодорхойлолтод хүргэдэг арга, “объектив байдал”, “объектив байдлын тодорхойлолт” зэрэг ойлголтуудын утга санаа, сорилтын аргын өөрийнхөн гүйцэтгэх үүрэг гээд – энэ бүхэн эдгээр өгөгдөхүүний өвөрмөц утгаас шалтгаална, ухаандаа тэдгээрийн өөрийнхөн мөн чанарын дагуух тухайн туршлагын ухамсраас (оршихуйн өөр хэлбэрийг биш, чухам тийм хэлбэрийн сэтгэхүйгээс) олгодог тэрхүү утгаас шалтгаална. Байгаль шинжлэлийг үлгэрлэн дагана гэдэг нь бараг л ухамсрыг байгальчлахаас өөрцгүй, энэ нь биднийг анхнаасаа зөрчилд оруулснаар судалгааны хуурмаг чиглэл, асуудлын зөрчилтэй тавилт руу хэлбийхэд хүргэдэг. Үүнээ илүү дөхөх гээд үзье.

Үгийн жинхэнэ утгаараа орон-цагийн биет ертөнц л гагцхүү байгаль мөн. Бусад индивидуаль оршигч, психик юм болбоос жинхэнээсээ бус, хоёрдогч утгаараа байгаль мөн бөгөөд энэ нь байгаль шинжлэлийн болон психологийн аргын гол ялгааг тодорхойлно. Зарчмын хувьд биет ахуй л шууд туршлагын олонлог дотор, өөрөөр хэлбэл хүртэхүйд адилсаг индивидуаль байдлаараа тодорхойлогдоно. Иймээс гагцхүү тэр нь олон субъектэд адилсаг индивидуаль юм мэт танин мэдэгддэг ба мөн тиймээрээ субъект дундын (intersubjectiv) байдалтай дүрслэгддэг. Ингэхдээ хүртэхүй нь олон “субъект”-ийн хооронд хуваагдсанаар сэтгэгддэг. Тэдгээр юмсын чанар байдал (эд юмс, үйл явцууд гэх мэт) бид бүхний нүдний өмнө байх ба бид тэдгээрийг уг (байгаллаг-орч.) чанарт нь тодорхойлох боломжтой. Тэдгээрийн уг (байгаллаг) чанар гэгч нь ийм юм: туршлага дахь олон янзын хувьсамтгай “субъектив” үзэгдлээр илрэн гарахдаа тэдгээр нь бас ч гэж үргэлжлэн хувьсах шинж чанаруудын цаг хугацаалаг нэгдлээрээ үлддэг, тэдгээрийг

* Юмс өөрийн мөн чанартай байдгийг феномэнологи шинжилгээнд удирдлага болгох ёстой. Эл мөн чанар/essence-ыг юмсыг туршин үзэх явцад “тохинуулан бүтээдэг”/ constitute гэж хэлж болно. Хожим “юмсын өөрт нь буцсугай!” хэллэг нь феномэнологи хөдөлгөөний гол уриа болсон байдаг.

нэгтгэгч нэгэн орон зай, нэгдсэн цаг хугацаа бүхий биет ертөнцийн нэгэн түгээмэл холбоост багтан орсноороо үлддэг. Тэдгээр нь гагцхүү энэхүү нэгдэлд, гагцхүү шалтгаант харилцан үйлчлэлд л тэдгээр мөн болой, эсвэл бие биеийнхээ харилцан холбоонд тэдгээр нь өөрийн адилсаг индивидуаль байдлыг (субстанцийг) хадгалдаг – түүнийг бодит шинж чанаруудыг тээгч мэт хадгалдаг. Бүхий л бодит шинж чанар нь казуаль шалтгаант шинжтэй. Оршин байгаа биет юмс бүхэн бололцоот өөрчлөлтийн хуульд өртдөг, харин эдгээр хуулиуд аваас адилсаг, тэгэхдээ өөрийнхөөрөө байгаа юмс биш, харин нэгдмэл байгалийн бодитой юмуу бололцоотой шүтэлцээнд орших юмсыг тухайлдаг. Бүхнийг багтаагч нэгдмэл байгалийн (der Einen Allnatur) доторх шалтгаанцуудыг нэгтгэх төв болдгийн улмаас юмс өөрийн уг чанартай байдаг. Бодит (эд юмт-бодит, биет) шинж чанар гэдэг нь энэхүү адилсаг юм хувьсан өөрчлөгдөх бололцооны казуаль хуулиудад заагдагч тэмдэг, иймээс тэр нь зөвхөн эдгээр хуулиудаар оршин байгаа зүйлийн харьцаанд тодорхойлогдохуйц байна. Тэгэхдээ юман чанар нь шууд туршлагын нэгдэл мэт өгөгдсөн нь мэдэхүйн олон үзэгдлүүдийн нэгдэлтэй адилхан юм. Мэдрэн хүртэгдэж байгаа хувьсах ба үл хувьсах шинж чанар, хувьслын хамаарал нь хаа сайгүй танин мэдэхүйн заалтыг илтгэх бөгөөд түүний тусын тулд ажиллах нь объектив үнэн физик байгалийг илрүүлэн гаргаж, сэтгэхүй (шинжлэх ухааны туршлагын сэтгэхүй болохын хувьд) үнэнг өөртөө тодорхойлж (herausbestimmt) бас бүтээхэд хүргэдэг “бүдэг” орчинд байгаа мэт байдаг¹⁶⁷.

Энэ бүхэн туршлагын юмст ба юмсын туршлагад зохиомлоор нэмж орхисон зүйл бус, харин тэдгээрийн мөн чанарт дараах байдлаар зайлшгүй холбогдолтой ямар нэгэн зүйл юм: хэрэг дээрээ эд юмс гэж юуг үзэх талаарх тууштай интуитив судалгаа бүхэн гарцаагүй казуаль холбоост хүрээд, зохих объектив шинжүүд зүй тогтолтойг тодорхойлсноор шувтардаг. Чингэхүйеэ байгаль шинжлэл нь туршлагаар танин мэдэгдсэн юм өөрөө юунд тэмүүлж байгаа гэмээр тэр утгыг огтоос хэлбэрэлтгүй мөрддөг. Үүнийгээ тэрээр “хоёрдогч чанарыг суутгахуй”, “анхдагч чанаруудыг авч үлдээд” “үзэгдлээс цэвэр субъектив зүйлийг суутгахуй” гэж тун тодорхойгүйгээр хэлдэг. Гэтэл энэ чинь бүр ч тодорхойгүй хэллэг: энэ бол байгаль шинжлэлийн зөв зүйтэй арга гэхэд муу онол билээ.

Одоо “психик юмс”-ын “ертөнц” лугаа хандацгаая. Ингэхдээ шинэхэн психологи өөрийнхөө судлагдахууны талбар мөн гэж үздэг “психик феномен”-уудаар хязгаарлагдъя. Өөрөөр хэлбэл, биднийг хэт хол аваачиж мэдэх сэтгэл-сүнс ба “би” зэрэг асуудлууд хойш тавигдаж байгаа юм. Ингээд психик юмсыг хүртэхүйд: физик туршлага хийгээд эд юмсыг хүртэхүйд байдагтай ижилхэн “байгальч”-объектив чанар ("Natur"-objektivitat) агуулагддаг уу? гэж өөрсдөөсөө асууцгаая. Психик юмсын хүрээнд байх харилцаа нь физик юмсын хүрээнийхээс тэс ондоо болохыг бид төвөггүй олж харна. Психик юмс (метафизик утга оруулалгүй, харьцуулан хэлбэл) хаалга цонхгүй монадуудын дунд тархсан байдаг, тэд хоорондоо зөвхөн догдлон мэдэхүйгээр харилцдаг. Психик ахуй, “феномэн” болох ахуй нь олон тусгаар хүртэхүй болгонд (нэгэн субъектийн хүртэхүйд ч ялгаагүй) адислаг-индивидуаль байдлаар танин мэдэгдэхүйц нэгдэл биш. Өөрөөр хэлбэл, психикийн хүрээнд үзэгдэл ба ахуй хоёрын хооронд ямар ч ялгаа байдаггүй, хэрэв байгаль нь үзэгдлүүдээр илрэн гардаг оршихуй мөн байхад, мөн ээлжинд үзэгдэл өөрөө (сэтгэлзүйчид үүнийг психик юм гэж тооцдог) үзэгдлүүдээр илэрдэг ахуй биш болой. Аливаа үзэгдлийн хүртэхүйн талаар эргэцүүлэн үзэхэд л энэ нь аяндаа илэрхий харагдана. Тийнхүү дараах зүйл тодорхой болж байна: гагцхүү юмсын үзэгдлүүдэд илрэн гарч байгаа ганц уг (байгаллаг) чанар бий. Өөрийнхөөрөө байгаа мэтээр үзэж, хамгийн өргөн утгаар психологи үзэгдэл гэж бидний нэрлэдэг бүхэн аваас байгаль биш, чухамдаа бол психик үзэгдэл мөн.

¹⁶⁷ Байгаль шинжлэлийн бясалгахуй ба сэтгэхүй ямагт дотор нь хөдөлж байдаг энэ феноменаль орчин нь тэдгээрийн шинжлэх ухааны сэдэв болдоггүй. Тэдгээрийг шинэ шинжлэх ухаанууд: психологи (үүнээ физиологийн сайн боловсрогдсон хэсэг хамаарна) ба феномэнологи хоёр авч үздэг

Иймээс үзэгдэл бол ямар нэгэн “субстанциональ” нэгдэл биш, түүнд ямар ч “бодит шинж чанар” байхгүй, тэр нь (хэрэв үгсийг байгаль шинжлэлийн утгаар ойлгон хэлбэл) ямар ч бодит хувь хэсгүүд, ямар ч бодит өөрчлөлт, ямар ч шалтгааллын талаар мэддэггүй. Феноменд* уг (байгаллаг) чанарыг оногдуулан, тэдгээрээс бодитой тодорхойлогдох хувь хэсгүүд хийгээд шалтгаант холбоог эрж хайх нь (хэн нэгэн тооны каузаль шинж чанар, холбоосны талаар олж мэдэхийг хүссэн үеийнхээс дээрдэх юмсгүй) огтоос утгагүй байдалд орно гэсэн үг. Энэ бол уг (байгаллаг) чанарт ахуй үгүй (тийм мөн чанартай) юмсыг байгальчилсанаас үүдсэн утгагүй байдал юм. Эд юмс байгаагаараа байдаг, ямагт адилсаг байдлаараа үлддэг: байгаль – мөнх. Бодитой буй юмст (практик амьдралын мэдрэгдэх юмс биш- “мэдрэхүүд илэрч байгаа” тэр юм биш, харин байгалийн юмст) байх шинж чанар хийгээд шинж чанарын хувилал болбоос объектив учир холбогдолтой тодорхойлогдохуйц байж, шинэ шинэ туршлагад нотолгож, бас засагдаж болдог. Харин психик юмс, “феномен” эсрэгээрээ, ямар ч адислаг үлдэх ахуйг агуулахгүйгээр ирдэг ба оддог. Өөрөөр хэлбэл, байгаль шинжлэлийн утгаар объектив тодорхойлогдохуйц, тухайлбал үгийн жинхэнэ утгаар “задлан шинжилгээ” хийгдэн, хувь хэсгүүдэд объектив хуваагдахуйц ахуй үгүй юм. Туршлага нь психик юмсын “байгаа”-г физик юмсыг учир холбогдолтой адилхан утгаар бидэнд хэлж өгч чадахгүй. Психик юм бол илрэн үзэгдэж буй юм мэт туршлага дахь мэдэгдэхүүн биш: тэр нь “амсах туршлага”, - тунгаан тусгах явцад ажиглан бясалгах замаар олж авсан туршлага; тэр нь үнэмлэхүй урсгалд өөрөө өөртөө бүтсэн мэт, төрмөгц мөхөх ба үзэхүүд тусахдаа аль хэдийнээ өнгөрөн одсон юм мэт илэрдэг. Психик юм бас дуртгалын зүйл байж, тэгснээрээ, тодорхой модификацид орсон утгаараа, туршлагын замаар танин мэдэгдсэн нэгэн болдог; дуртгалын зүйлд “хүртэгдэж байсан юм” агуулагддаг; тэр нь түүнийг тогтоон барьж байгаа ухамсарт нийцлийг олсноор дурсан санахуйд “дахин давтагдсан” дуртгалын зүйл болдог. Түүний адилсаг байж чадах гагцхүү тийм “давталтууд”-ад психик юмсын адилсал тогтож, оршин байгаа юм болохыг нь а priori туршлагаар танин мэдэж болно. Чухам ийнхүү туршлагаар мэдэгдсэн психик юмс бүхэн нэгэн зүйл цогц холбоост, ухамсрын “монадлаг” нэгдэлд шингэн орсон байдаг (үүнийг бид баттай хэлж чадна). Тэрхүү нэгдэлд байгаль, орон, цаг, субстанциаль чанар, шалтгаалтай дүйцэх юм юу ч байхгүй боловч тэр нь өөрийн өвөрмөц “хэлбэрүүдтэй”. Психик юм бол түүнийг туулан өнгөрсөн (бүхнээ нэвтэрхий нэгдлийн жагсаалт мэт байдаг) интенциональ шугамтай нэгдэл бүхий хоёр талаасаа хязгаарлагдаагүй феномэнуудын урсгал юм. Энэ бол эхлэл төгсгөлгүй имманент “цаг хугацаа”-ны шугам, ямар ч хронометрээр хэмжигдэхгүй.

Бид имманент ажиглах бясалгалд үзэгдлүүдийн урсгалыг мөшгин үзэхдээ нэг феномэнээс нөгөө феномэн руу (тэдгээр нь тус бүрдээ урсгал доторх нэгдэл байх ба өөрсдөө урсгалд татагдан ордог) шилжин орох бөгөөд феномэнээс өөр юутай ч тулгарахгүй. Имманент ажиглах бясалгал ба юмсын туршлага хэлний илэрхийллийг олсны дараагаар л бясалгалд өртсөн феномэн ба туршлагад мэдэгдсэн юм хоёр тодорхой харилцаанд орно. Юмсын туршлага, харилцааны тухай тийм туршлагын танин мэдэхүй болбоос психик юмсыг дам бясалгахуйн нэгэн төрөл, хоёрдогч монадлаг холбоост бясалган нэвтрэхүй болох догдлон мэдрэхүйг бас гаргаж ирдэг.

Тэгвэл цаашдаа энэ талбарт зохистой судалгааг хэрхэн явуулах вэ? Түүний талаарх үнэн учир холбогдолтой хэллэг хэрхэн бололцоотой болох вэ? Бүдүүн бараг дүрслэл хэлбэрээр (бүрэн цар хүрээгээр нь дуугаралгүй өнгөрөөсөн) бидний сая хэлсэн тийм хэллэгүүд хаа хүртэл зөвшөөрөгдөх вэ? Хэрэв судалгаа “психик юмс”-ын туршлагын танин мэдэхүй болох нь илэрсэн “туршлага”-ын утгад бүхэлдээ чиглэгдсэн байвал, тэгэхдээ “психик юмс”-ыг онож

* "Phänomen"/ Феномэн нь үзэгдлийг заах боловч ямар нэгэн зүйлийн илрэл бус болох нь дээрх хэсгийн бичвэрээс тодорхой харагдана. Феномэнологид өөрөө өөртөө тодрон үзэгдэх гоц чанарт үзэгдлийг феномэн гэдэг.

тодорхойлохын тулд яг тэгж ажиглан бясалгахыг шаардаж байгаа тийм бэлгэ чанарыг нь тогтоон барьж, тодорхойлохыг оролдвол тэнд тэр (судалгаа) нь утга учиртай байх болно; иймд, нэн түрүүнд утгагүй хоосон байгальчлахуйг эс үйлдэх ёстой. Урьд дурдсанчлан, феномэнийг өгөгдөж байгаагаар нь, өөрөөр хэлбэл урсан байгаа энэ ухамсар (Bewussthaben), сэтгэхүй (Meinen), үзэгдлээр (Erscheinen) нь, наадах цаадах талын яг энэ ухамсар (Vordergrundbewussthaben und Hintergrundbewussthaben)-ын хувьд тэдгээр нь хэрхэн илэрч байгаагаар нь онон барих хэрэгтэй; одоо бол одоогийн, одоогоос өмнөх бол өмнөхийн, уран сэтгэмжийн бол сэтгэмжийн, дүрст тэмдгийн бол тэмдгийн, тусгасан бол тусгалын зүйлийн ухамсрын хувьд хэрхэн илэрч байгаагаар нь; тэгэхдээ энэ бүхнийг юутай ч аль нэгэн үндэслэл, аль нэгэн аттакциональ модуст (attaktionalen modi) бүрэлдэн тогтон, өөрчлөгдөн хувьсаж буй зүйл болох хувьд нь онон барих хэрэгтэй. Энэ бүхэн хамтдаа: “тухай ухамсар” (Bewusstsein von) гэж нэрлэгдэх бөгөөд тогтсон “утгатай байж”, “оногдохууныг” (Gegenstandliches) “сэтгэдэг”- энд оногдохуун гэж байгаа нь аль нэгэн үзэл бодлын үүднээс “зохиомол юм” гэж нэрлэгддэг ч байг хамаагүй – “имманент оногдохуун” болох нь, “сэтгэлд тэгж тусгагдсан юм” болох нь, мөн өөр бусад модуст тусгагдах (vermeint) нь дүрслэгдэхүйц байх учиртай.

Энэ “туршлагын” талбарын утгаас гажихгүйгээр бид энд судалж, нотолж, илтэд чанартай хэллэгийг үйлдэж болох нь бүхнээс тодорхой. Мэдээж, заасан шаардлагыг биелүүлэх нь ихээхэн бэрхшээлтэй; энд гүйцэтгэвэл зохилтой судалгааны нийцэл зөрчил болбоос “феномэнологи” удирдамжийн цэвэр, тууштай байдлаас гойд хамаарна. Эрт балар цагаас натуралист атгаг үзлээр амьдарч, сэтгэж (тиймээс психик юмыг натуралист байдлаар гуйвуулж) дадсан бидэнд түүнээс салах нь бэрх. Хэрэг дээрээ психик юмсын (энд чухам феномэналь зүйлийг үгийн хамгийн өргөн утгаар авсан) “цэвэр имманент” судалгаа (сая психофизик судалгаанд эсрэгцүүлэн ерөнхий тодорхойлж гаргасан бөгөөд бид эдүгээ хүртэл тэр талаар бодолцон үзээгүй авч өөрийн зохих ёсны эрхтэй судалгаа) бололцоотойг ухаарахаас цаашид олон зүйл шалтгаална.

Психик юмс өөртөө байгаагаараа байгаль биш, харин түүнд эрс эсрэгцсэн нэгэн хэмээвээс бид юуг түүний “ахуй” гэж тооцох вэ? Тэр нь “объектив” адислаг байдлаараа тодорхойлогдошгүйгээс хойш ахин давтан ажиглаж, тэгснээрээ шинжлэх ухаан-туршлагын замаар тогтоон нотлох боломжтой бодит шинж чанаруудын субстанциаль нэгдэл хэрхэх билээ?, нэгэнт мөнхийн урсгалаас таслан авч, түүнд субъект дундын учир холбогдолтой объектив чанарыг олгож болохгүйгээс хойш бид түүний юуг нь онож, түүний талаар тодорхой өгүүлж, объектив нэгдэл болохын нотлох билээ? Ингэхэд бид цэвэр феномэнологийн орчинд байж, эд юмс-мэдрэн хүртэгдэх бие ба байгаль тэргүүтэнд харьцах харилцаа суутгагдсаныг мартах ёсгүй. Хариулт ийм байдалтай: нэгэнт гоц үзэгдэл байгаагаараа бол уг чанаргүй ч тэд шууд ажиглах бясалгалд онож болох мөн чанартай; тэдгээрийг тохирсон ойлголтоор дүрслэн үзүүлж байгаа аливаа нотломж, хэрэв ач холбогдолтой хэвээрээ үлдсү хэмээвээс үүнийг мөн чанарын ойлголтуудаар, өөрөөр хэлбэл мөн чанарын бясалгалд л шийдвэрлэгдэх тийм үгэн хийсвэр утгуудаар үйлдэнэ.

Психологийн аливаа аргуудын эл эцсийн үндсийг ойлгох нь зүйтэй. Бид бүхнийг эрхшээхдээ биднийг уг (байгаллаг) чанараас татгалзах, мөн психик юмсыг психофизик байдалд нь биш, харин цэвэр төлөвт нь ажиглан бясалгахуйн судлагдахуун болгох чадваргүй болгож байгаа натуралист атгаг үзлийн хараал болбоос нэг талаар жинхэнэ шинжлэх ухааны психологийн үндсэн нөхцөл болох, өөр талаар оюун ухааны үнэн шүүмжлэлийн талбар болох, үр дагавраараа жишигдэшгүй нүсэр шинжлэх ухааны талбарт нэвтрэх боломжийг энд хаачхаж байгаа юм. Балар цагийн натурализмын хараал мөнхүү бид бүхэн “мөн чанар”, “санаа”-г олж харах буюу тэдгээрийг байгальчлахгүйгээр өвөрмөц байдалд нь зөв танин ухаарахад маш бэрх байдагт оршино (тийм авч бид тэдгээрийг яаж хийгээд ямагт олж хардаг). Мөн чанарын бясалгахуйд хүртэхүйгээс хэтийдсэн бэрхшээл юмуу “мистик” нууц агуулагддаггүй. Бид “өнгө”-

ийг бүрэн өгөгдсөн байдалд нь бүрэн тодорхойгоор интуитив ухаарахад өгөгдөхүүн нь мөн чанар болж хувирна; тийм цэвэр бясалгалд хүртэхүйгээс хүртэхүй рүү шилжсээр “хүртэхүй”, өөртөө буй хүртэхүй (хүртэхүйн янз бүрийн хувьсамтгай хэсгүүдийн эл өөртөө адилсаг чанар) болох тэр өгөгдөхүүнд дээшлэн хүрэхэд бид мөн чанарт “хүртэхүй”-г ухаарна. Интуици, бясалгагч ухамсар байвал харгалзах (“Logischen Untersuchungen” зохиолд миний нэрлэснээр) “идейжүүлэлт” буюу “мөн чанарыг бясалгахуй”-н бололцоо байсаар байна. Чингэхүйеэ, энэ нь “психик”-ийн бүх талбарыг, имманент зүйлийн бүх талбарыг багтаадаг. Мөн чанарлаг бясалгахуйд ухаарсан “мөн чанар”, наад заах нь ерөнхий төрхөөрөө, тогтвортой ойлголтуудад тэмдэглэгдсэн байж болох нь, ингэснээр тогтвортой бөгөөд өөрийн хүрэнээ объектив, үнэмлэхүй учир холбогдолтой нотолгоонуудад бололцоо нээгдэж байгаа нь атгаг үзлээс ангид хүн бүхэнд аяндаа илэрхий. Өнгөний хамгийн нарийн ялгарал, эцсийн ялгаврыг тэгж тэмдэглэн тогтоох боломжгүй байж мэдэх ч “дуу”-наас “өнгө”-ний ялгарах нь анзаарахгүй байхын аргагүй илэрхий ялгааг бий болгодог. Тийм үнэмлэхүй ялгагдахуйц, нэг ёсондоо тэмдэглэн тогтоох бололцоотой мөн чанарт: мэдрэхүйн “агуулга” ба үзэгдлийн (“үзэгдэхүйц юмс”, “хийсгэлэн дүр”-гэх мэтийн) мөн чанараас гадна үгийн шууд утгаар психик юм бүхний мөн чанар (хүртэхүй, уран сэтгэлэг, дурсан санахуй, бодомж, мэдрэмж, хүсэл зориг зэргийн тоолшгүй олон зүйл тийм психик баримтад харгалзах “би”-гийн төлөв байдлын мөн чанар, аливаа “акт”-ын мөн чанар) бүгд тооцогдоно; хэдийгээр ажиглан бясалгахуйн замаар ухааран тогтоогдсон “санаа”-тай урсан өнгөрөхүйн дүрслэгдэхүйц хэв маяг нь үнэмлэхүй мэдлэгийг боломжтой болгодог авч “урсгал”-ын тодорхойлогдошгүй агшинд оногдох эцсийн “ялгавар”-ууд энд хамаарахгүй үлдэнэ. Хүртэхүй аль эсвэл хүсэл зориг гэх зэрэг ямар ч психологи нэршил нь мөн чанарын судалгаа буюу, өөрөөр хэлбэл “ухамсрын шинжилгээ”-ний ямар нэгэн өргөн талбарын нэршил болно. Иймд, хэдий хачин санагдаж мэдэх ч, далайцаараа гагцхүү байгаль шинжлэлтэй эн тэнцэхүйц тийм өргөн салбарын талаар яригдаж байгаа хэрэг.

Мөн чанарлаг бясалгал нь хүртэхүй, санахуй юмуу түүнтэй төстэй актуудын утгаар авсан “туршлага”-тай дүйцэх юмгүй, цаашилбал туршлагын тусгаар хувь хэсгүүдээс экзистенциаль утгаар авсан эмпирик ерөнхийлөлтэй хавтах юмгүй гэдэг баримт шийдвэрлэх ач холбогдолтой байна. Бясалгахуй аваас мөн чанарыг мөн чанарлаг ахуй болохын хувьд бясалган ажигладаг болохоос оршихуйн ямар ч утгаар авч үздэггүй, ажигладаггүй. Ийн үзэхүйд, мөн чанарыг бясалгахуй бол matter of fact –ийн танин мэдэхүй биш, индивидуаль оршихуйн талаар ямар ч өнгө аясыг агуулдаггүй. Мөн чанарлаг бясалгахуйн(хүртэхүй, санахуй, бодомж зэргийг мөн чанарт бясалгахуй) цаад учир буюу, энгийнээр хэлбэл анхдагч акт нь ямар нэгэн хүртэхүй, санахуй, бодомж зэргийн хүртэхүй байж болно; өөрөөр бол бас энгийн атал “илэрхий” уран сэтгэмж байж болох бөгөөд чухам тэр нь байгаараа бол туршлага биш, ямар ч оршихуйг ухаарахыг шаардахгүй шүү дээ. Мөн чанарыг ухаарах нь үүнээс огт шалтгаалахгүй; тэр нь ажиглан бясалгаж байгаагаараа л мөн чанарын ухаарахуй болдог; энэ нь туршлагаас огт өөр ажиглан бясалгахуй мөн. Мөн чанар нь бүрэг буюу, ухаандаа бэлгэт тэмдгээр төсөөлөгдөж болох ба мөн худал тогтоогдож болно, - тэр тохиолдолд зөрчилд ороогдсон хуурмаг мөн чанар бидний өмнө байж, ажиглах бясалгалд шилжин ормогц тэдгээрийн нийцгүй нь мэдэгддэг; ямартаа ч мөн чанарлаг өгөгдөхүүний интуицийн тусламжтайгаар мөн чанарын бүрхэг тогтсон байдал хангалттай нотлогдох бололцоотой. Мөн чанарт агуулагдаж байгааг, ийм онцлогтой ийм зүйлийн мөн чанар тийм нэгэн өөр мөн чанартай хэрхэн нэгдэж, жишээлбэл “бясалгахуй” ба “хоосон сэтгэгдэл” хоёр, “уран сэтгэмж” ба “хүртэхүй” хоёр, “ойлголт” ба “бясалгал” хоёр гэх мэт нь хоорондоо хэрхэн нэгдэж байгааг, тэдгээр нь мөн чанарын тийм тийм элементийн үндсэн дээр хэрхэн зайлшгүйгээр “сэргэн бүтэж” (ухаандаа бие биедээ нийцэж) байгааг, “интенци”, түүний хэрэгжилт буюу хэрхэн тэд нийцэшгүй болох аль эсвэл “ухамсрын урам хугарал”-ыг өдөөж байгааг тогтвортой, тохиромжтой ойлголтод тусган тэмдэглэж байгаа бодомж бүр – нэг ёсондоо

тийм бодомж бүр үнэмлэхүй, түгээмэл холбогдолт танин мэдэхүй мөн бөгөөд түүнийг туршлагаар нотлох, үндэслэх эсвэл мөн чанарын талаарх бодомж хэмээн ниргэх гэх нь утгагүй байхсан. Тэр нь өөртөө “relation of idea” буюу нэгэнтээ Хюмийн мэлмийд өртсөн нэгэн зүйлийн *ariori*-ийг тэмдэглэдэг. Тэрбээр мөн чанарыг “impression”-ий эсрэг “idea” болгож позитивист төөрөгдөл орсон билээ. Түүний скептицизм энд эцэстээ хүртэл тууштай байж зүрхлээгүй, тэр бүү хэл ийм танин мэдэхүйд эргэлзэнгүй хандаж байв. Хэрэв түүний сенсуализм нь “ухамсар”-ын интенциональ чанарын бүх талбарт түүнийг харалган болгож орхиогүй бол, тэрээр түүнийг мөн чанарын судалгаанд хамааруулсан бол, тэрээр агуу спектик үзэлтэн биш, харин оюун ухааны жинхэнэ “эерэг” онолыг үндэслэгч байх байлаа. “Treatise”-даа махран оролдсон ч түүнийг төөрөгдлөөс төөрөгдөлд хүргэсэн тэдгээр асуудлууд, тэрээр бүр өөрийн атгаг үзлийн улмаас хэмжин зөв томьёолж дийлэхгүй байсан асуудлууд – бүгд гарцаа байхгүй феномэнологийн салбарт хамаарна; ухамсарт бүрэлдлийн мөн чанарлаг холбоос болон түүнд харьцангуй, түүнд нягт уялдаатай сэтгэгдэл чанарыг (*Gemeintheiten*) шинжлэх замаар утга учиртай нэг ч асуудлыг үлдээлгүйгээр тэдгээрийн бүрэн шийдлийг ерөнхий бясалгахуйн ойлгоцоос олно. Тухайлбал, юмсаас авах сэтгэгдэл хийгээд хүртэхүйн олон янз байдлын эсрэг юмсын адилсаг байдлын нэн чухал асуудлыг аваад үзвэл, олон янзын хүртэхүй (бас үзэгдэл) өөрөө өөртөө болон тэдгээрийн нэгдэл ба адилслын ухамсарт хэрхэн “нэг л юм” болгон “өөрийгөө илрүүлээд” байгаа асуудал үнэхээр феномэнологи судалгаагаар л шийдвэрлэгдэх боломжтой (мэдээж, түүний талаарх бидний томьёолол үүнийг зааж байна). Энэ асуудал дээр эмпирик-байгалийн шинжлэлийн хариулт өгөх гэх нь түүнийг ойлгохгүйгээр үл барам утгагүй болгож байгаа хэрэг. Ерөөс аливаа туршлага төдийгүй хүртэхүй нь чухам тэгж баримжаалсан, тэгж өнгө аяс оруулсан, хэлбэржүүлсэн зүйлийн хүртэхүй мөн болж байгаа нь түүний мөн чанарыг тооцоололтой холбогдолтой болохоос юмсын “оршихуйн” талаар юуг ч хөндөөгүй ажээ. Түүнчлэн энэ л хүртэхүй хүртэхүйн үл тасалдах эгнээ дотор байрлаж, тэгэхдээ тэр эгнээ нь дур зоргын зүйл биш, харин түүнд “нэг л юм шинэ тутам олон хэлбэрүүдэд өөрийгөө илрүүлж байгаа” гэх мэт нь бас л гагцхүү мөн чанарт хамааралтай байна. Нэг үгээр хэлбэл, энд сэтгэлгээний талаар хараахан гүйцээгүй “ухамсрын шинжилгээ”-ний талбартай бид дайралдаж байна. Чингэхдээ ухамсрын ба психикийн ойлголтын зохицлын асуудлыг хэрэгсэхгүйгээр бүхий л имманент зүйлийг, тэгэхлээр ухамсарт сэтгэгдэн буусан зүйл бүрийг утгад нь тэмдэглэж чадахуйц чинээгээр судалгааг явуулах учиртай. Олон зууны турш хэлэлцсээр эцэстээ өөрийг нь гуйвуулагч натурализмаас салж байгаа үүсэл гарвалийн асуудал нь үнэндээ феномэнологийн асуудал мөн. Тухайлан, “орон зайн төсөөллийн” үүсэл, цаг хугацааны, юмсын, тооны төсөөллийн үүсэл, шалтгаан ба үр дагаврын “төсөөлөл”-ийн үүсэл зэргийг дурдаж болох юм. Эдгээр цэвэр асуудлууд учиртай томьёологдон шийдэгдсэн цагт л хүмүүний ухамсрын үзэгдэл болох тийм төрлийн төсөөллийн бусад эмпирик асуудлууд шинжлэх ухаанчаар ойлгогдохуйц, тэдгээрийн шийдэлд тустай утгыг олж авна.

Дуу авиаг шууд сонсож болдгийн адилхан “мөн чанар”, “дуу авиа”-ы мөн чанар, “эд юмт үзэгдэл”-ийн мөн чанар, “үзэгдэх юмс”-ын мөн чанар, “дүрэн төсөөлөл”-ийн мөн чанар мэтсийг ажиглан бясалгаж, бас ажиглан бясалгангаа мөн чанарлаг бодомж дүгнэлтийг өгүүлж болдгийг зүй ёсных хэмээн үзэхэд хамаг хэргийн учир оршино. Нөгөөтээгүүр, феномэнологи бясалгалыг “өөрийгөө ажихуй”-тай, дотоод туршлагатай хольж хутгадаг, нэг ёсондоо мөн чанараас илүүтэй тухайн индивидуаль шинж байдлыг үзэх актуудаас ялгаж чаддаггүй Хюмын будлианаас сэрэмжлэх хэрэгтэй¹⁶⁸.

¹⁶⁸ Нэгэн тогтолцоот феномэнологийн зүйлсийг агуулсан «Логик судалгаа» зохиолд энд дурдагдаж байгаа мөн чанарын шинжилгээ анх хийгдсэн боловч өөрийгөө ажихуйн аргыг сэргээх оролдлого хэмээн ямагт ташаа ойлгогдож ирсэн. Мэдээж хэрэг, хоёрдугаар ботийн эхний судалгааны “Оршил”-д аргыг хангалттай тодорхойлж чадалгүй феномэнологийг тоочин дүрслэх психологи хэмээн тэмдэглэсэнд хамаг учир буй.

Цэвэр феномэнологи нь байгалийн талаар экзистенциаль үндэслэлийг хэрэглэхээс хөндий, бие тусгаар байгаа цагт, шинжлэх хааны хувьд оршихуйн судалгаа биш, харин мөн чанарын судалгаа байж болно; ямар ч “өөрийгөө ажигхуй”, тийм “туршлага” дээр үндэстэй ямар ч бодомж түүний хязгаарт багтахгүй. Тусгаар юмсын имманент чанарыг энд л чингэж өрнөж байгаа !гэж (чухам энд ийшээ чиглэгдсэн хүртэхүй, санахуй гэх мэтээр) үзэж болох бөгөөд мөн чанарын шинжилгээний ачаар үүссэн, мөн чанарын чанд ойлголтуудаар илэрхийлэгдсэн байна. Хэдийгээр индивидуум мөн чанар биш болов чиг эрх биш учир холбогдлынхон талаар илэрхий хэлж болохуйц өөртөө байх мөн чанар –“тай байна”. Тийм эгэл дэд-ухвар түүний индивидуум болохыг тогтоож, индивидуаль оршихуйн “ертөнц”-д түүний байр суурийг заах чадваргүй. Түүний хувьд нэгж юм бол мөнхийн *apeiron* болж үлдэнэ. Феномэнологи нь мөн чанар болон мөн чанаруудын харилцааг л объектив учир холбогдолтойгоор танин мэдэж чадна. Үүгээрээ аливаа эмпирик танин мэдэхүй төдийгүй ерөөс аливаа танин мэдэхүйг тодорхой ойлгоход тустай бүхнийг бүрэн гүйцэт үйлдэнэ: аливаа формаль-логик болон байгаль ёсны-логик зарчмуудын (бусад аливаа хөтөч зарчмуудын) “үүсэл”-ийг, мөн энэ бүхэнтэй нягт холбоотой “ахуй” (байгалийн, үнэлэмжийн гэх мэт) ба “ухамсар”-ын шүтэлцээний асуудлыг тайлна.

Асуудлын психофизик тавилт руу орцгооё. Энд “психик зүйл” гэдэг нь түүнд шингэсэн бүх чанар байдлын хамт бие хийгээд физик байгалийн нэгдэл хамаарах харилцааг олж авдаг: имманент ажиглан хүртэхүй болон тийм хэлбэрт танин мэдэгдсэн нэгэн мэдрэн хүртэгдсэн зүйлтэй, тэгэхлээр байгальтай холбоонд ордог. Гагцхүү тийм харьцахуйгаар дамжин тэр нь дам байгальтай адилтгах объектив чанарыг олж авдаг, дам байдлаар байгалийн орон зайд байраа олдог бөгөөд бид цагаар хэмждэг байгалийн цаг хугацааны шугамд орж ирдэг; туршлагын талаар физик зүйлээс “хамааралт байдал” нь тодорхой боловч чиг нарийвчлалгүй хэмжээгээр психик зүйлийг индивидуаль ахуй болохыг тогтоох, мөн илүү олон жишээн дээр психофизик харилцааг субъект дундын байдлаар судлах бололцоог олгодог. Энд, “психологи нь байгаль шинжлэл”-ийн хүрээнд байдаг нь үгийн жинхэнэ утгаар психофизик (мөн эмпирик) психологи мөн.

Мэдээж, “психик зүйл”-ийн тухай шинжлэх ухаан, психологийг “психик феномэн” болон тэдгээрийн биетэй харилцах харилцааны тухай шинжлэх ухаан л юм гэж үзэх нь бэрхшээлийг тойрон байгаа явдал биш. Тэр нь *De facto* хаа сайгүй төрлөхийн, зайшгүй объективизациудыг мөрдлөг болгодог бөгөөд тэдгээрт дүйцэх зүйл нь хүн ба адгуусны эмпирик нэгдэл, нөгөө талаас сэтгэл, бие хүн юмуу бие хүний төлөвшил, зан чанар зэргийн нэгдэл байдаг. Тэгтэл бидний зорилгын үүднээс бол эл нэгдлийн бүрэлдэл үндсэн шинжилгээний араас мөшгиж, тэдгээр нь өөртөө психологийн зорилтыг хэрхэн тодорхойлж байгаа асуудлаар оролдох шаардлагагүй. Эдгээр нэгдэл нь, угтаа өгөгдөхүүн буюу үзэгдлийн сүүдэрт өгөгдсөн зүйлс болсон байгалийн биет чанараас зарчмын ялгаатай байдгийг тийм нэгдэлд хамааруулах хэлж огт болохгүй нь даруй мэдэгдэнэ. Хүн өөрөө биш, гагцхүү суурь үндэс болсон “хүний бие” нь биет үзэгдлийн нэгдэл мөн: ямар ч тохиолдолд бие хүн, зан чанар... зэрэг нь тийм биш. Тийм аливаа нэгдэл бидэнд ухамсрын бүх урсгалын амьдралын имманент нэгдэл болон тийм олон янзын имманент нэгдлийг ялгаж байгаа морфологи онцлогуудыг илэрхий зааж өгдөг. Үүнээс улбаалан аливаа психологи танин мэдэхүй ухамсрын тэр мэт нэгдэлд, тиймээс феномэн хийгээд тэдгээрийн шүтэлцээг судлахад хүргэдэг. Тэр бүү хэл, тэр нь хүний хувийн зан чанар, сэтгэлзүйн онцлогийг судлах үест ч адилхан тийм байна.

Ерөөс, ялангуяа бүгдийг өчсөний дараа, дээр өгүүлсэн зүйлийг маш тодорхой, ул суурьтай хүлээн зөвшөөрөх хэцүү байх нь юу л бол: чухамдаа психофизик (ө.х ердийн

“Archiv für systematische Philosophie(1903), 397–400” дахь 1895—1899 оны үес, логикийн герман утга зохиолын талаарх миний гуравдах тоймд зайлшгүй шаардлагатай нэмэлтүүдийг тусгасан болно.

психологи) танин мэдэхүй нь хэдийнээ психик зүйлийн мөн чанарлаг танин мэдэхүйг шаарддаг бөгөөд дурсан санахуй, шүүн бодохуй зэргийн мөн чанарыг психофизик сорилтын замаар болон казуаль шалтгаант дотоод хүртэхүй буюу туршлагаар судлах найдвар, тийм замаар психофизик нотолгоонууд дахь психик зүйлийн тэмдэглэгээнд (мөн эдгээр нотолгооны өөрт нь) шинжлэх ухааны үнэ цэнийг гагцхүү олгож чадах чанд ойлголтуудад хүрэх зорилготой итгэл найдвар бол гуйвалтын оргил мөн.

Орчин цагийн психологийн үндсэн алдаа, үгийн жинхэнэ шинжлэх ухааны утгаар психологи болоход түүнд саад болж байгаа зүйл бол тэр нь энэхүү феномэнологи аргыг мэдэхгүй, түүнийг хөгжүүлэхгүй байгаа явдал юм. Түүхэн атгаг үзэл нь түүнийг ойлголтуудыг тодотгоход чиглэгдсэн аливаа шинжилгээнд байх тийм аргын анхны мэдэгдэхүүнийг ашиглахаас түүнийг хөндийрүүлж орхисон. Ихэнх сэтгэл судлаачид феномэнологийн нэгэнт бэлэн байгаа анхны мэдэгдэхүүнийг ойлгоогүй, заримдаа бүр цэвэр интуитив явагдаж байгаа мөн чанарын шинжилгээг метафизик-схоластик дэд хийсвэрлэл гэж үзэж байсан явдал үүнтэй холбоотой. Ажиглан бясалгахуйн мэдэгдэхүүн болон дүрслэгдсэн зүйл нь зөвхөн ажиглан бясалгахуйд л ойлгогдож, дахин судлагдаж болдог.

Энэ бүхнийг өгүүлсний эцэст, психик зүйлийн тухай эмпирик (яг үнэндээ тохирохуйц) шинжлэх ухаан нь нэгэн тогтолцоот феномэнологид тулгуурласан цагт л түүний байгалийн харилцааны учир олдох нь тодорхой; чингэхүйеэ: цэвэр интуитив судлагдан тогтоогдсон ухамсрын бүрэлдэл болон түүнээс имманент уялдаатай юмс болбоос бүхий л бололцоот феномэний тухай ойлголтын (иймээс сэтгэлзүйч-эмпирист өөрийн психофизик бодомжуудад психик зүйлийг өгүүлэхэд ашигладаг тэдгээр ойлголтын) шинжлэх ухааны утга агуулгад өөрийн хэм хэмжээг тогтоох сон; – энэ нь хойшдоо нийтэд хүлээн зөвшөөрөгдөнө гэж найдах шалтаг надад бий. Гагцхүү үнэхээрийн тууштай, нэгэн тогтолцоот феномэнологи - тохиолдлын шинжтэй хэсэг бусад эргэцүүлүүдэд биш, харин ухамсрын дээд зэргийн ээдрээтэй асуудалд бүрэн төвлөрсөн феномэнологи л хувийн төдийгүй нийгмийн хүрэн дэх “психик зүйл”-ийн талаарх ойлгоцыг бидэнд олгож чадна. Тэгвэл, гагцхүү тэр цагт манай үеийн сорилтын ажлууд, цугларсан эмпирик баримтуудын хуримтлал хийгээд зарим талаар сонирхолтой тогтмолууд нь зохих шүүмжлэл, психологи тайлбарлалын ачаар бодитой үр дүнг өгөх болно. Тэгвэл, орчин цагийн психологийн тухайд: психологи нь философитой ойр, бүр нэн ойрын харилцаанд оршдог гэж хэрхэвч хэлж болохгүйтэй санал нийлэх хэрэгтэй болно. Тэгвэл, танин мэдэхүйн онол нь психологжсон онол байх ёсгүй гэдэг антипсихологизмын парадокс ер бусын байдалтай санагдахгүй, учир нь жинхэнэ танин мэдэхүйн онол бүр зайлшгүйгээр феномэнологи дээр тулгуурлах ёстой, тийнхүү аливаа философи ба психологийн ерөнхий суурь болох учиртай. Тэгвэл, эцэст нь, сүрхий шинжлэх ухаанч чанарын эрмэлзэл бүхий байж, байгаль шинжлэлийн, нэн түрүүнд “сорилт-психологийн нөөц”-д тулгуурлан бидэнд өөрийн танин мэдэхүйн онолоо, өөрийн логикийн онолоо, ёс зүйгээ, натурфилософио, сурган хүмүүжүүлэхүйн ухаанаа санал болгодог, эдүгээ бороон дараах мөөг шиг дэлгэрч буй философийн тэр хуурмаг утга зохиол байх боломжгүй болно. Эдгээр зохиолыг хараад, үнэхээр хүн төрөлхтний аугаа суутнууд өөрийн амьдралаа зориулсан тэдгээр асуудал, бэрхшээлийн ухамсрын уналтын тухайд халаглахаас өөр яах билээ; бас харамсалтай нь, сорилтот психологийн өөрийнхөн хүрээнд ч (бидний үзлээр, түүнд төрлөхийн байдаг зарчмын шинжтэй доголдуудыг үл харгалзан) бидэнд гүн хүндэтгэл төрүүлдэг жинхэнэ нямбай үндэс суурьтай байдлын уналтын тухайд адилхан юм. Эдгээр утга зохиолын түүхэн үнэлгээ нь XVIII зуунд түгэн дэлгэрч ихээхэн зэмлэлд өртсөн философийн түүхэн үнэлгээг бодвол яваандаа илүү чангарна гэдэгт би бат итгэлтэй байна.

Энд хүрээд сэтгэлзүйжсэн натурализмын будилаантай талбарыг орхицгооё. Локкын үеэс хүчирхэгжсээр ирсэн психологизм нь, магадгүй философийн феномэнологи үндэслэгээнд чиглэгдсэн цорын ганц зөв зүйтэй философийн хандлага боловсрох ёстой бүрхэг хэлбэр байсан

гэж хэлж болох юм. Мөн феномэнологи шинжилгээ нь мөн чанарын шинжилгээ, үгийн жинхэнэ утгаар априори шинжилгээ байхын хэрээр априоризмын зөв зүйтэй санал сэдэл бүхнийг бүрэн харгалзана. Ямар ч тохиолдолд, натурализмыг зарчмын хувьд алдаатай философи гэж хүлээн зөвшөөрөх нь чанд шинжлэх ухааны философиос, “доороос эхлэх философиос” татгалзана гэсэн үг биш болохыг манай шүүмжлэл тодорхой харуулах учиртай. Психологи аргыг феномэнологи аргаас шүүмжлэн ялгах нь феномэнологийн хувьд оюун ухааны тухай шинжлэх ухааны онолд, мөн хангалттай сайн психологид хүрэх зөв замыг зааж өгнө.

Бидний төлөвлөгөө ёсоор, бид одоо түүхчлэх үзлийн шүүмжлэлд шилжиж, ертөнцийг бясалгахуйн философийг хэлэлцэнэ.